




МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ 2025



www.supremecourt.mn



ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1.ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА.....	2
1.1.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ.....	3
1.2.ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ.....	8
1.3.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ.....	12
2.ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖИЛ.....	20
2.1.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ.....	20
2.2.ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ.....	33
2.3.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ.....	47
3.ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЛБА.....	59
4.МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР.....	65
4.1.ЗАХИРГАА УДИРДЛАГА.....	65
4.2.ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА.....	76
4.3.ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	81
4.4.УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ.....	94
4.5.МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ЦАХИМЖУУЛАЛТ.....	97
4.6.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ.....	107


НЭГ. ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Улсын дээд шүүхэд хяналтын шатны шүүх хуралдаанаар 2025 онд эрүүгийн 132, иргэний 236, захиргааны 101, сахилгын 1, нийт 470 хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Улсын дээд шүүхэд хүлээн авсан нийт 2887 хэрэг




МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД 2025 ОНД ХҮЛЭЭН АВСАН ХЭРГИЙГ 2024 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТ



1.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл хяналтын журмаар хүлээн авсан **8** хэрэг, нэмж хяналтын шатны журмаар **953**, шүүхийн харьяалал тогтоолгохоор **13**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулах болон цагаатгалын **9**, нийт **983** хэрэг хүлээн авснаас **1** хэрэгт гомдол гаргагч гомдлоосоо татгалзсан, **5** хэргийг хуульд заасан бусад үндэслэлээр танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзан буцааж, танхимын нийт шүүгчийн хуралдаанаас **820** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **132** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **13** хэрэгт шүүхийн харьяаллыг тогтоох хүсэлтийг шийдвэрлэж, **2** хэрэгт гомдлоос татгалзсаныг хүлээн авч, нийт **10** хэргийн үлдэгдэлтэй байна.

НИЙТ ХҮЛЭЭН АВСАН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ 983



Тайлангийн хугацаанд Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **947** хэргийн гомдол болон холбогдох шүүхийн шийдвэрүүдийг хэлэлцсэнээс **820** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **127** (өмнөх оны үлдэгдэл 8 хэргийг хассан) хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.



Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар шийдвэрлэсэн **947** хэргийг шүүгдэгчийн гаргасан **292**, шүүгдэгчийн өмгөөлөгчийн гаргасан **826**, хохирогчийн гаргасан **55**, хохирогчийн өмгөөлөгчийн гаргасан **89**, иргэний хариуцагчийн гаргасан **14**, иргэний нэхэмжлэгчийн гаргасан **2**, прокурорын бичсэн **142** эсэргүүцлээр буюу нийт **1420** гомдол, эсэргүүцлээр хянан хэлэлцжээ.


Хяналтын шатын эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **132** хэргийг зүйлчлэлээр авч үзвэл:

Эрүүгийн хуулийн Аравдугаар бүлгээр **18**, Арван нэгдүгээр бүлгээр **15**, Арван хоёрдугаар бүлгээр **21**, Арван тавдугаар бүлгээр **6**, Арван долоодугаар бүлгээр **13**, Хорьдугаар бүлгээр **2**, Хорин нэгдүгээр бүлгээр **4**, Хорин хоёрдугаар бүлгээр **11**, Хорин гуравдугаар бүлгээр **1**, Хорин дөрөвдүгээр бүлгээр **6**, Хорин долоодугаар бүлгээр **24**, шийдвэр гүйцэтгэлийн **1**, шинээр илэрсэн нөхцөл байдал болон цагаатгалын **10**, нийт **132** хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн.


Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаан **34** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **3.9** хэрэг, танхимын нийт шүүгчийн хуралдаан **40** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **23.7** хэрэг хэлэлцжээ.

Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар танхимын тэргүүн Ч.Хосбаяр **720**, шүүгч Б.Амарбаясгалан **855**, Б.Батцэрэн **867**, Ц.Оч **348**, Д.Батбаатар **428**,

С.Соёмбо-Эрдэнэ **953**, М.Пүрэвсүрэн **878**, Б.Цогт **898** хэргийн гомдлыг тус тус хянан хэлэлцсэн байна.



Хяналтын журмаар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **132** хэргийн **12.9** хувь буюу **17** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, **45.5** хувь буюу **60** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, **41.6** хувь буюу **55** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон байна.




Өөрчлөлт оруулсан **60** хэргийн **80.0** хувь буюу **54** хэргийг Эрүүгийн хууль буруу тайлбарлан хэрэглэсэн, **1.7** хувь буюу **1** хэргийг Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр тогтоол, магадлалд тус тус өөрчлөлт оруулж, **8.3** хувь буюу **5** хэргийн ял шийтгэлийг хөнгөрүүлжээ.

Хүчингүй болгосон **55** хэргийн **10.9** хувь буюу **6** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, **60.0** хувь буюу **33** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, **10.9** хувь буюу **6** хэргийн анхан шатны тогтоолыг хүчингүй болгож, магадлалыг хэвээр үлдээсэн, **7.3** хувь буюу **4** хэргийн тогтоол, магадлалын зарим заалтыг хүчингүй болгож, **10.9** хувь шинээр илэрсэн нөхцөл байдал болон цагаатгалын хэрэг **6** хэргийг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Тайлант хугацаанд танхимын тэргүүн Ч.Хосбаяр **13**, шүүгч Б.Амарбаясгалан **23**, Б.Батцэрэн **22**, Б.Цогт **21**, С.Соёмбо-Эрдэнэ **22**, М.Пүрэвсүрэн **24**, Д.Батбаатар **9**, Ц.Оч **8** хэргийг тус тус хүлээн авчээ.



Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд танхимын тэргүүн Ч.Хосбаяр **65**, шүүгч Б.Амарбаясгалан **101**, Д.Батбаатар **60**, Б.Батцэрэн **109**, Ц.Оч **48**, М.Пүрэвсүрэн **106**, С.Соёмбо-Эрдэнэ **106**, Б.Цогт **89** удаа тус тус оролцсоноос;


Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **18**, шүүгч Б.Амарбаясгалан **16**, Д.Батбаатар **10**, Б.Батцэрэн **17**, Ц.Оч **12**, М.Пүрэвсүрэн **19**, С.Соёмбо-Эрдэнэ **27**, Б.Цогт **19** удаа шүүх хуралдааныг даргалж;

Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **10**, шүүгч Б.Амарбаясгалан **23**, Б.Батцэрэн **20**, Ц.Оч **6**, М.Пүрэвсүрэн **23**, С.Соёмбо-Эрдэнэ **21**, Б.Цогт **20** Д.Батбаатар **9** эрүүгийн хэргийг илтгэж,

Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **30**, шүүгч Б.Амарбаясгалан **57**, Б.Батцэрэн **63**, Ц.Оч **26**, М.Пүрэвсүрэн **57**, С.Соёмбо-Эрдэнэ **55**, Б.Цогт **45**, Д.Батбаатар **10** хэргийн бүрэлдэхүүнд оролцсон байна.

Эрүүгийн хэргийн танхим 2025 онд нийт **168** албан бичиг хүлээж авснаас шүүгч Б.Амарбаясгалан **6**, Б.Батцэрэн **15**, Ч.Хосбаяр **112**, С.Соёмбо-Эрдэнэ **15**, М.Пүрэвсүрэн **5**, Б.Цогт **4**, Д.Батбаатар **3**, Ц.Оч **8** албан бичгийг, мөн хугацаанд **26** өргөдөл, гомдол хүлээн авснаас шүүгч Б.Амарбаясгалан **1**, Ч.Хосбаяр **21**, М.Пүрэвсүрэн **2**, С.Соёмбо-Эрдэнэ **2**, өргөдөл, гомдол тус тус хүлээн авч, шийдвэрлэжээ.

ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНД ШҮҮГЧДИЙН ОРОЛЦОО, АЛБАН БИЧИГ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ



Цагаатгалын үнэмлэхийг олгох бэлтгэл ажиллагааг нийт 3 удаа хийж, Ерөнхий шүүгчид танилцуулж, 1 албан бичгийн хариугаар шийдвэрлэж, (№17264-17265)-ийг олгож, гарт нь гардуулж өгсөн.

Цагаатгалын 5 хэргийн 5 хэлмэгдэгчийг цагаатгаж, цагаатгалын бүртгэлд 5 хэлмэгдэгчийн мэдээллийг шинээр оруулж, мөн нийт 26 хэлмэгдэгчдийн мэдээллийг нөхөн хөтөлсөн.

Шинээр олгосон 2 цагаатгалын үнэмлэхийг цахим санд бүртгэж, 21 аймаг, 9 дүүргээс ирүүлсэн нөхөх олговор олгосон нийт 49 шүүхийн шийдвэрүүдийн мэдээллийг оруулсан.

Мөн хяналтын шатны захиргаа, иргэний хэргийн шүүх хуралдаан болон танхимын нийт шүүгчийн хуралдааны бүрэлдэхүүнд танхимын тэргүүн Ч.Хосбаяр **24**, шүүгч Б.Батцэрэн **10**, Б.Цогт **13**, Б.Амарбаясгалан **16**, С.Соёмбо-Эрдэнэ **3**, М.Пүрэвсүрэн **13**, Ц.Оч **41** удаа оролцжээ.




Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **200** гарснаас шүүхийн харьяалал тогтоох тухай **6**, шүүгч томилон ажиллуулах тухай **194** захирамж гарчээ. Мөн танхимын зөвлөгөөний тогтоол **92**, шүүхийн тогтоол **47**, мэдэгдэх хуудас **101**, шүүгчийн **7** тусгай санал гарсан байна.

Тухайлбал, шүүгч Б.Амарбаясгалан 2, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Амарбаясгалан нар хамтран 2, Б.Батцэрэн 2, Д.Батбаатар 1 тусгай саналыг тус тус бичиж нийтлүүлсэн байна.

1.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ


Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл хяналтын журмаар хүлээн авсан **18** хэрэг, нэмж хяналтын шатны журмаар **1261**, харьяалал тогтоолгохоор **20**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **24**, нийт **1323** хэрэг хүлээн авснаас **982** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **27** хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхгүй буцааж, **236** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **2** хэргийг гомдол гаргаагүйд тооцож, **22** хэргийн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг хэлэлцэж, **20** хэрэгт шүүхийн харьяаллыг тогтоож, нийт **34** хэргийн үлдэгдэл /хяналтын журмаар хүлээн авсан 32, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлттэй 2/-тэй байна.

Тайлангийн хугацаанд Иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаан **42** өдөр хуралдаж, нийт **1261** хэрэг хэлэлцсэнээс **250** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр, **982** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **2** хэрэг хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, **27** хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхгүй буцааж шийдвэрлэсэн байна.



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны болон танхимын нийт шүүгчийн хуралдаан нийт **81** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **19** хэрэг хэлэлцжээ.

Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **1158**, шүүгч Н.Батзориг **1279**, Н.Батчимэг **1187**, Н.Баярмаа **1097**, П.Золзаяа **941**, Э.Золзаяа **453**, Б.Ундрах **296**, Д.Цолмон **1077**, Х.Эрдэнэсүвд **1175** хэргийн гомдлыг тус тус хянан хэлэлцсэн байна.



Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн иргэний **236** хэргийн **19.1** хувь буюу **45** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **18.2** хувь буюу **43** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, **35.2** хувь буюу **83** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, **22** хувь буюу **52** хэргийн магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, **5.5** хувь буюу **13** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.




Өөрчлөлт оруулсан **83** хэрэг нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **43** хэргийн **79.1** хувь буюу **34** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, **2.3** хувь буюу **1** хэргийг Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, **9.3** хувь буюу **4** хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн **9.3** хувь буюу **4** хэргийг нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **13** хэргийн **7.7** хувь буюу **1** нь зохигчийн эвлэрлийг баталсан, **92.3** хувь буюу **12** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлттэй **22** хэргийг тайлангийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд **22** хэргийн хүсэлтийг хангаагүй байна.

Хяналтын журмаар танхимын тэргүүн Г.Алтанчимэг **17**, шүүгч Н.Батзориг **34**, Н.Батчимэг **36**, Н.Баярмаа **35**, П.Золзаяа **26**, Э.Золзаяа **11**, Б.Ундрах **7**, Д.Цолмон **35**, Х.Эрдэнэсүвд **35** хэрэг тус тус шинээр хүлээн авчээ.




Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **111**, шүүгч Н.Батзориг **114**, Н.Батчимэг **97**, Н.Баярмаа **110**, П.Золзаяа **79**, Э.Золзаяа **34**, Б.Ундрах **24**, Д.Цолмон **98**, Х.Эрдэнэсүвд **110** бүрэлдэхүүнд оролцож;

Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **38**, шүүгч Н.Батзориг **46**, Н.Батчимэг **36**, Н.Баярмаа **36**, П.Золзаяа **20**, Э.Золзаяа **7**, Б.Ундрах **8**, Д.Цолмон **35**, Х.Эрдэнэсүвд **34** хуралдааныг тус тус даргалж;

Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **17**, шүүгч Н.Батзориг **34**, Н.Батчимэг **36**, Н.Баярмаа **35**, П.Золзаяа **26**, Э.Золзаяа **11**, Б.Ундрах **7**, Д.Цолмон **35**, Х.Эрдэнэсүвд **35** хэргийг тус тус илтгэсэн байна.

Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2024 оны бүтэн жилийн байдлаар хяналтын хуралдаанд оролцсон байдал



Тус танхим 2025 оны бүтэн жилд иргэн, хуулийн этгээдээс нийт **55** албан бичиг хүлээн авснаас Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **15**, шүүгч Н.Батзориг **4**, шүүгч Н.Батчимэг **5**, шүүгч Н.Баярмаа **5**, шүүгч П.Золзаяа **7**, шүүгч Э.Золзаяа **4**, шүүгч Б.Ундрах **1**, шүүгч Д.Цолмон **9**, шүүгч Х.Эрдэнэсүвд **5** албан бичиг,

29 өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **4** өргөдөл, гомдол, шүүгч Н.Батзориг **5** өргөдөл, гомдол, шүүгч Н.Батчимэг **5** өргөдөл, гомдол, шүүгч Н.Баярмаа **5** өргөдөл, гомдол, шүүгч П.Золзаяа **2** өргөдөл, гомдол, шүүгч Д.Цолмон **3** өргөдөл, гомдол, шүүгч Х.Эрдэнэсүвд **5** өргөдөл, гомдол тус тус хүлээн авч хянан шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **236** хэргийн хэргийн **42.8** хувь буюу **101** хэргийг нэхэмжлэгчийн, **49.6** хувь буюу **117** хэргийг хариуцагчийн, **5.9** хувь буюу **14** хэргийг зохигчийн, **1.7** хувь буюу **4** хэргийг прокурор, гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **236** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Иргэний хуулиар **176**, Хөдөлмөрийн тухай хуулиар **32**, Гэр бүлийн тухай хуулиар **16**, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **2**, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **3**, бусад хуулиар **7** хэргийг хянан шийдвэрлэжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилсон шийдвэрийг албажуулах тухай” **281** захирамж,

Шүүхийн тогтоол **81** гарснаас “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт шийдвэрлэсэн” **22**, шүүх хуралдаан хойшлуулсан **41**, хүсэлт шийдвэрлэсэн **18** тогтоол,

Танхимын нийт шүүгчийн хуралдааны тогтоол **1296** гарснаас, хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай **258**, шүүхийн харьяалал тогтоох

тухай **6**, тогтоол албажуулах хугацаа сунгах тухай **4**, хуралдаан хойшлуулах тухай **5**, хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тухай **990**, гомдлоосоо татгалзсан **2**, гомдлыг хэлэлцэхгүй буцаах тухай **27**, шүүх хуралдаанаас татгалзан гарах хүсэлт шийдвэрлэсэн **4** тогтоол тус тус гарсан байна.

1.3.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

Захиргааны хэргийн танхим 2024 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл хяналтын журмаар гомдол гаргасан **546** хэрэг, давж заалдах журмаар **20** хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлт **6**, өмнөх оны үлдэгдэл **7** хэрэг, нийт **579** хэрэг хүлээн авсан байна.

Хяналтын журмаар хүлээн авсан **546** гомдлын **416** гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **19** гомдлыг “хяналтын журмаар гомдол гаргах хугацаа хэтэрснийг буцаах тухай” **7**, “хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй этгээд гомдол гаргасныг буцаах тухай” **8**, “хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй үндэслэлээр буцаасан тухай” **3**, “хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзсаныг буцаах тухай” **1** үндэслэлээр буцааж, **111** гомдлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээн авсан **111** хэргийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т заасан үндэслэлээр:

- 123.2.1-д заасан үндэслэлээр **11.7** хувь буюу **13** хэрэг;
- 123.2.2-т заасан үндэслэлээр **10.8** хувь буюу **12** хэрэг;
- 123.2.3-т заасан үндэслэлээр **9.9** хувь буюу **11** хэрэг;
- 123.2.4-т заасан үндэслэлээр **9** хувь буюу **10** хэрэг;
- **2** буюу түүнээс дээш үндэслэлээр **58.6** хувь буюу **65** хэрэг байна.

Тайлант хугацаанд хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээж авсан **111** хэрэг, өмнөх оны үлдэгдэл **5** хэрэг, нийт **116** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхээс **107** хэргийг шийдвэрлэж, одоо үлдэгдэл **9** хэрэг байна.


Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн **107** хэргийн:

- **101** хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолтой;
- **2** хэргийг нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн тогтоолтой;
- **2** хэргийг нэхэмжлэгч, хариуцагч эвлэрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн тогтоолтой;
- **2** хэргийг хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, гомдол гаргаагүйд тооцсон шүүхийн тогтоолтой.

Түүнчлэн тайлант хугацаанд давж заалдах журмаар **20** хэрэг хүлээн авч, өмнөх оны үлдэгдэл **2** хэрэг, нийт **22** хэрэг хянан шийдвэрлэхээс **17** хэрэг нь давж заалдах журмаар хянан хэлэлцсэн тогтоолтой, **1** хэрэг нь давж заалдах журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, гомдол гаргаагүйд тооцсон шүүгчийн захирамжтай, одоо үлдэгдэл **4** хэрэг байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах **6** хүсэлт хүлээн авч, тайлант хугацаанд **6** хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.


НИЙТ ХҮЛЭЭН АВСАН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ 579



1. Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны 101 хэргийн:

- шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон **17.8** хувь буюу **18** хэрэг;
- магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн **11.9** хувь буюу **12** хэрэг;
- шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан **29.7** хувь буюу **30** хэрэг;
- магадлалыг хүчингүй болгож, шийдвэрт өөрчлөлт оруулсан **5** хувь буюу **5** хэрэг;
- шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангасан **10.9** хувь буюу **11** хэрэг;
- шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон **3** хувь буюу **3** хэрэг;
- шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан **12.9** хувь буюу **13** хэрэг;
- магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр давж заалдах шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн **6.9** хувь буюу **7** хэрэг;
- шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон **2** хувь буюу **2** хэрэг байна.

ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ-101



2. Давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны 17 хэргийн:

- шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон **41.2** хувь буюу **7** хэрэг;
- шийдвэрт өөрчлөлт оруулсан **11.8** хувь буюу **2** хэрэг;
- шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр давж заалдах шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн **17.6** хувь буюу **3** хэрэг;
- шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн **17.6** хувь буюу **3** хэрэг;
- шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангасан **11.8** хувь буюу **2** хэрэг байна.

3.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлттэй 6 хэргийг тайлангийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд хүсэлтийг хангаагүй 6 байна.

Захиргааны хэргийн танхимын танхимын нийт шүүгчийн хуралдаан **41** өдөр, хяналтын шатны шүүх хуралдаан **32** өдөр, нийт **73** өдөр хуралдсан, өдөрт дунджаар **9** хэрэг хэлэлцжээ.

Давж заалдах журмаар болон хяналтын журмаар хэлэлцсэн нийт 118 хэрэгт гомдол гаргасан хэргийн оролцогч		тоо	хувь
Үүнээс	Нэхэмжлэгч	28	23.7%
	Хариуцагч	16	13.5%
	Гуравдагч этгээд	10	8.5%
	Итгэмжлэгдсэн төлөөлөгч	40	34%
	Өмгөөлөгч	24	20.3%

Давж заалдах журмаар болон хяналтын журмаар хэлэлцсэн нийт 118 хэргээс талуудын гаргасан гомдлыг шийдвэрлэсэн байдал		Хангасан	Зарим хэсгийг хангасан	Хангаагүй
Үүнээс	Нэхэмжлэгч талаас гаргасан гомдол	28	9	27
	Хариуцагч талаас гаргасан гомдол	16	2	18
	Гуравдагч этгээд талаас гаргасан гомдол	10	2	6
Нийт тоо, хувь		54 буюу 45.8%	13 буюу 11%	51 буюу 43.2%

Хянан шийдвэрлэсэн 118 хэргийн маргааны төрөл																
Хяналтын журмаар														Давж заалдах журмаар		нийт
Газар	Төрийн алба	Татвар	Ашигт малтмал	Сонгууль	Тендер	Улсын бүртгэл	Тусгай зөвшөөрөл	Байгаль орчин	Оюуны өмч	Нийтийн өмч	Өрсөлдөөн	Нийгмийн даатгал	Бусад	Хэм хэмжээний акт	МХХ	
18	16	14	10	3	3	6	3	1	2	1	1	5	15	8	9	118

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **30,817,800** (гучин сая найман зуун арван долоон мянга найман зуу) төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **24,640,200** (хорин дөрвөн сая зургаан зуун дөчин мянга хоёр зуу) төгрөгийг буцаан олгожээ.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМЫН ШҮҮГЧДИЙН 2025 ОНЫ АЖЛЫН АЧААЛАЛ




Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанд:

Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **517**, шүүгч Г.Банзрагч **552**, шүүгч Д.Батбаатар **298**, шүүгч М.Батсуурь **523**, шүүгч Х.Батсүрэн **393**, шүүгч П.Соёл-Эрдэнэ **562**, шүүгч Ц.Цогт **479**.

Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын дээд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг сугалаагаар томилох журам”-ын 5.3-т заасны дагуу Эрүү, Иргэний хэргийн танхимын гомдол хэлэлцэх нийт шүүгчийн хуралдаанд шүүгч П.Соёл-Эрдэнэ **76**, Г.Банзрагч **68**, М.Батсуурь **59**, Д.Батбаатар **31**, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **21**, шүүгч Х.Батсүрэн **4**, Ц.Цогт **1** гомдлыг тус тус хянан хэлэлцэх бүрэлдэхүүнд орсон байна.

Захиргааны хэргийн танхимын шүүгчийн ажлын ачаалал



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд

Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **99**:

- Шүүх хуралдаан даргалсан-**18**
- Хэргийг илтгэсэн-**12**
- Бүрэлдэхүүнд орсон-**69**

шүүгч Г.Банзрагч **109**:

- Шүүх хуралдаан даргалсан-**20**
- Хэргийг илтгэсэн-**22**
- Бүрэлдэхүүнд орсон-**67**

шүүгч Д.Батбаатар **47**:

- Шүүх хуралдаан даргалсан-**8**
- Хэргийг илтгэсэн-**9**
- Бүрэлдэхүүнд орсон-**30**

шүүгч М.Батсуурь **95**:

- Шүүх хуралдаан даргалсан-**19**
- Хэргийг илтгэсэн-**23**
- Бүрэлдэхүүнд орсон-**53**

шүүгч Х.Батсүрэн **73**:

- Шүүх хуралдаан даргалсан-**14**
- Хэргийг илтгэсэн-**17**
- Бүрэлдэхүүнд орсон-**42**

шүүгч П.Соёл-Эрдэнэ **110**:

- Шүүх хуралдаан даргалсан-**22**
- Хэргийг илтгэсэн-**23**
- Бүрэлдэхүүнд орсон-**65**

шүүгч Ц.Цогт **97**:

- Шүүх хуралдаан даргалсан-**26**
- Хэргийг илтгэсэн-**24**
- Бүрэлдэхүүнд орсон-**47**

Захиргааны хэргийн танхим нь **79** албан бичиг (Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **16**, шүүгч М.Батсуурь **13**, П.Соёл-Эрдэнэ **12**, Г.Банзрагч **12**, Ц.Цогт **11**, Х.Батсүрэн **9**, Д.Батбаатар **6**);

30 өргөдөл (Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа **7**, шүүгч Ц.Цогт **6**, Г.Банзрагч **5**, П.Соёл-Эрдэнэ **4**, М.Батсуурь **3**, Х.Батсүрэн **3**, Д.Батбаатар **2**) тус тус хүлээн авч, танхимын нийт шүүгчийн хуралдаанд танилцуулж, хариу өгчээ.

Улс төрийн намын бүртгэл хөтлөх журамд заасны дагуу **12** өргөдөл хүлээн авч, Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **6** өргөдлийг хэлэлцэн буцааж, **1** өргөдлийг Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн. Одоо **5** үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд шүүгчийн захирамж **59** гарснаас, “хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай” **19**, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **36**, “улсын тэмдэгтийн хураамж буцаах тухай” **1**, “давж заалдах журмаар гомдол гаргаагүйд тооцох” **1**, “хяналтын журмаар гомдол гаргаагүйд тооцох” **1**, “хүсэлт хэлэлцэх шүүх хуралдааныг товлох тухай” **1**;

Шүүхийн тогтоол **29** гарснаас, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **15**, “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлт шийдвэрлэсэн” **6**, “тогтоолд залруулга оруулах тухай” **3**,

“нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон” 2 тогтоол, “нэхэмжлэгч, хариуцагчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон” 2, “хяналтын журмаар гомдол гаргаагүйд тооцох тухай” 1 тус тус гаргажээ.

Танхимын нийт шүүгчийн хуралдааны тогтоол **563** гарснаас, “хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **419**, “хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай” **112**, “хяналтын журмаар гомдол гаргах хугацаа хэтэрснийг буцаах тухай” **8**, “хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй этгээд гомдол гаргасныг буцаах тухай” **8**, “хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй үндэслэлээр буцаасан тухай” **4**, “хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзсаныг буцаах тухай” **1**, “хэргийн харьяалал тогтоох тухай” **4**, “хуралдаан хойшлуулах тухай” **5**, “хүсэлт шийдвэрлэсэн тухай” **1**, “тогтоол залруулга хийх тухай” **1** тогтоол тус тус гарчээ.

Танхимын шүүгчдийн зөвлөгөөний тогтоол **7** гарснаас, “шүүхийн шийдвэр гаргах хугацаа сунгах тухай” **5**, “ачаалал тэнцвэржүүлэн хэрэг шилжүүлэх тухай” **1**, “шүүхийн шийдвэр гаргах хугацаа болон хэрэг хянан шийдвэрлэх хугацааг сунгах тухай” **1** тогтоол гаргасан байна.

Шүүхийн шийдвэрийн хураангуй 7 гаргаснаас:

Шүүгч Г.Банзрагч

- “Хууль үйлчлэх үед ажиллаж байсан алба хаагч урамшуулал авах эрхтэй”;
- “Өндөр насны тэтгэвэр авагч нас барснаас хойш түүний гэр бүлийн хүн нь тэтгэврээ нэмэгдүүлэх эрхтэй”;

Шүүгч П.Соёл-Эрдэнэ

- “Газрыг эргүүлэн авахдаа нөхөх олговор олгоно”;
- “Монголын үндэсний их сургууль” НҮТББ-ын нэхэмжлэлтэй хэргийн талаар;

Шүүгч Ц.Цогт

- “Газрын дуудлага худалдааны зарыг газрын биржийн цахим системээр заавал мэдээлэх үүрэгтэй”;
- “Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн газрын төлбөрийг уурхайн эдэлбэр газрын хэмжээгээр ногдуулж төлнө”;
- “Хууль ёсны итгэл хамгаалах зарчим үйлчилнэ” талаар тус тус бичиж, Улсын дээд шүүхийн цахим хуудаст байршуулсан байна.

Шүүгчийн тусгай санал 1: Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа “Д.Сайнбилэгийн нэхэмжлэлтэй, Баянзүрх дүүргийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэг”-т тусгай санал бичсэн.

Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаанд илтгэж оруулсан асуудлууд:

Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа

- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн “Үндэсний шударга байдлын тогтолцооны үнэлгээний “Улс төрийн нам” хэсгийн тайланд санал, дүгнэлт авах тухай” албан бичгийн танилцуулга;

➤ Улс төрийн нам үүсгэн байгуулагдсаныг болон намын шинэчилсэн дүрэм бүртгэхтэй холбоотой зарим асуудал;

Шүүгч Г.Банзрагч

➤ Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17.1 дүгээр зүйлийн 27 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах эсэх асуудлыг шийдвэрлэх;

➤ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь заалтыг тайлбарлах тухай;

➤ Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралаас 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн ХЭГ/1028 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Худалдан авах ажиллагааны тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн төсөл”-д өгөх саналын танилцуулга;

Шүүгч Д.Батбаатар

➤ Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд хүргүүлэх нэмэлт тайлбарын танилцуулга;

Шүүгч М.Батсуурь

➤ Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн дарга Н.Ганибалын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн тодруулга хүсэх тухай, мөн Н.Ариунболдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн нээлттэй мэдээлэл авах тухай албан бичгүүдийг тус тус танилцуулах;

Шүүгч П.Соёл-Эрдэнэ

➤ Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатараас 2025.04.23-ны өдрийн УИХ-13/5050 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-д өгөх саналын танилцуулга;

➤ Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлээс 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 1/2075 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл”-д өгөх саналын танилцуулга;

Шүүгч Ц.Цогт

➤ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3-т заасны дагуу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгох саналыг хууль санаачлагчид уламжлах тухай саналын танилцуулга;

➤ Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд хүргүүлэх нэмэлт тайлбарын танилцуулга;

➤ Шүүгчдийн зөвлөгөөн-Захиргааны хэргийн дээд шүүхийн Олон улсын холбоо (IASAJ)-нд гишүүнээр элсэх боломжийн талаар танилцуулга.

ХОЁР. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖЛЫН ТАЛААР

Улсын дээд шүүхийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимууд нь Монгол Улсын шүүхийн тухай хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан чиг үүргийн хүрээнд зөвхөн хэрэг маргаан хянан шийдвэрлэхээс гадна хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, шүүгчдийн мэргэшлийг дээшлүүлэх, шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлуудыг тоймловол:

- Хууль, журам, эрх зүйн баримт бичгийн төсөлд өгсөн санал: 33
- Боловсруулж, хэлэлцүүлсэн баримт бичиг: 101
- Ном, гарын авлага, судалгааны материал: 7
- Мэргэшүүлэх болон заавал судлах сургалт, хичээл: 34
- Хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон тоо: 145
- Ажлын хэсэгт оролцсон байдал: 57
- Олон нийтэд чиглэсэн контент, мэдээлэл: 12
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн ярилцлага: 7

2.1.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

Боловсруулсан баримт бичиг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тайлбарлах тухай тогтоолын төслийг боловсруулахад оролцсон.	Илтгэгч шүүгч Б.Батцэрэн,
2	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь заалтыг тайлбарлах тухай албан ёсны тайлбар гаргахтай холбогдуулан санал өгч оролцсон.	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
3	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025.01.22-ны өдрийн 1/445 дугаар албан бичгээр ирүүлсэн “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд санал боловсруулсан.	Илтгэгч шүүгч Б.Батцэрэн, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
4	Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжинээс 2025.03.13-ны өдрийн Улсын Их Хурал-03/2881 дүгээр албан бичиг болон Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлээс 2025.03.20-ны өдрийн 1/1436 дугаартай албан бичгээр тус тус ирүүлсэн “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-д өгөх саналыг боловсруулсан.	Илтгэгч Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
5	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025.05.14-ний өдрийн 1/2557 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд санал боловсруулсан.	
6	Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025.04.15-ны өдрийн УИХ/13/4572 дугаар албан бичгээр ирүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй хамт боловсруулсан Эрүүгийн, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулсан.	Илтгэгч шүүгч Б.Амарбаясгалан, Б.Батцэрэн

7	Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгсөн.	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
8	Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын 2025.05.08-ны өдрийн УИХ-03/5882 дугаар албан бичгээр санал авахаар ирүүлсэн “Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл буюу Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд танхимуудаас санал авч нэгтгэн, Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	Илтгэгч шүүгч М.Пүрэвсүрэн, шүүгч Б.Амарбаясгалан Б.Батцэрэн Д.Батбаатар
9	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025.01.21-ний өдрийн 1/365 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах буюу 20.18 дугаар зүйл (Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг зогсоох) нэмэх хуулийн төсөлд танхимуудаас санал авч нэгтгэн, Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	Илтгэгч шүүгч М.Пүрэвсүрэн, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
10	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025.01.21-ний өдрийн 1/363 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн “Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд санал өгсөн.	Илтгэгч шүүгч С.Соёмбо-Эрдэнэ, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
11	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгсөн.	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
12	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025.04.22-ны өдрийн 1/2075 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөлд санал өгсөн.	Илтгэгч шүүгч С.Соёмбо-Эрдэнэ, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
13	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025.06.02-ны өдрийн 1/3024 дугаартай албан бичгээр ирүүлсэн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд санал өгсөн.	Илтгэгч шүүгч Б.Батцэрэн, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
14	Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгээс ирүүлсэн “Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх саналыг Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	Илтгэгч шүүгч Д.Батбаатар, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
15	Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатараас 2025 оны 01/1249 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд санал өгсөн.	Илтгэгч шүүгч Б.Батцэрэн
16	ХЗБХ-ны дарга Д.Цогтбаатараас ирүүлсэн 2025 оны УИХ-ын 08/11494 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зохих өөрчлөлтийг оруулах тухай хуулийн төсөлд өгөх саналыг Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	

17	Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатараас 2025.10.02-ны өдрийн 1/1519 дүгээр албан бичиг, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангаас 2025.10.08-ны өдрийн УИХ-03/11596 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд санал өгсөн.	Илтгэгч шүүгч С.Соёмбо-Эрдэнэ, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
18	Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2025.09.22-ны өдрийн 1/1335 дугаар албан бичгээр ирүүлсэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан боловсруулсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”, 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 1/2307 дугаар албан бичгээр ирүүлсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, УИХ-ын гишүүн Х.Болормаагаас 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн УИХ-03/13448 дугаар албан бичгээр болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 1/2492 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлээд, санал хүргүүлэхээс татгалзаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд буцаахаар шийдвэрлэсэн.	Илтгэгч Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, М.Пүрэвсүрэн, Б.Цогт, С.Соёмбо-Эрдэнэ
19	Иргэний хэргийн танхимын боловсруулсан “Улсын дээд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг сугалаагаар томилох журам”-ын төсөлд санал өгсөн.	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
20	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгсөн.	Шүүгч Б.Батцэрэн, Б.Амарбаясгалан
21	Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгсөн.	Шүүгч Б.Батцэрэн
22	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгсөн.	
23	“Монголын шүүгчдийн холбооны гишүүний татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын төсөлд санал өгсөн.	
24	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дүрэмд санал хүргүүлсэн.	
25	2025 онд анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээс хүүхдийн эрхийг хангах, оролцох, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг нэгтгэн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд хүргүүлсэн.	Шүүгч Ц.Оч
26	Иргэний зориг ногоон намын дарга Б.Батбаатараас Улсын дээд шүүхэд 2025.10.13-ны өдөр “...намын дүрмийн шинэчилсэн найруулга, хөтөлбөрийг бүртгүүлэх” өргөдөл ирүүлснийг танхимын нийт шүүгчийн 2025.10.27-ны өдрийн	

	хуралдаанаар хэлэлцэж, 2025.11.04-ний өдрийн 02/3497 дугаар албан бичгээр буцааж шийдвэрлэсэн.	
27	Улс төрийн намын бүртгэлээс ирүүлсэн хүсэлтийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд танилцуулж, тогтоолын төслийг боловсруулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
28	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенцыг хэрхэн ойлгож, тайлбарлах талаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд танилцуулсан.	
29	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 2/1347 дугаар “Тайлбар хүсэх тухай” албан бичгийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд танилцуулсан.	
30	Улс төрийн намын бүртгэлээс ирүүлсэн хүсэлтийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25.8.1-д заасны дагуу 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны 08 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах саналыг танилцуулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
31	Үнэн ба зөв намын даргыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай 2025.02.05-ны өдөр намын дарга А.Отгонбаатараас ирүүлсэн өргөдлийг хүлээн авч, Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ
32	Танхимын нийт шүүгчийн 2025.11.04-ний өдрийн хуралдаанаар “Либертари нам үүсгэн байгуулсныг бүртгүүлэх тухай өргөдлийг хэлэлцээд, буцааж шийдвэрлэсэн.	
33	Иргэний хөдөлгөөний намын дарга Ө.Баяраагаас 2024.12.23-ны өдөр “Намын нэрийн өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэх” тухай өргөдлийг хүлээн авч, Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	
34	Ардчилсан намын дарга Л.Гантөмөрөөс 2025.09.03-ны өдөр “О.Цогтгэрэлийг Ардчилсан намын даргаар бүртгэж өгнө үү” гэсэн агуулга бүхий өргөдлийг хүлээн авч, 2025.09.18-ны өдөр Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	Шүүгч Б.Амарбаясгалан
35	Их эв намын үүсгэн байгуулагч З.Бат-Отгоноос 2025.10.21-ний өдөр “З.Бат-Отгоныг намын даргаар бүртгэж өгнө үү, намын дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэж өгнө үү” гэсэн агуулга бүхий өргөдлийг хүлээн авч, 2025.11.19-ний өдрийн Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	
36	Үнэн ба зөв намын дарга А.Отгонбаатараас ирүүлсэн “Намын дарга, дүрмийн нэмэлт өөрчлөлтийг бүртгүүлэх” тухай өргөдлийг хүлээн авч, Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
37	Ардчилсан намын дүрмийн өөрчлөлт бүртгүүлэх тухай өргөдлийг хүлээн авч, Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулан, өргөдлийг буцаасан.	
38	Иргэдийн Оролцооны Нэгдэл нам (ИОНН)-ын дарга Ц.Оюунгэрэлээс 2025.01.30-ны өдөр ирүүлсэн “ИОНН-ын	Шүүгч

	дүрэм (шинэчилсэн найруулга)-д орсон нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай” өргөдлийг хүлээн авч, Нийт шүүгчийн хуралдаанаар илтгэж танилцуулсан.	М.Пүрэвсүрэн
39	“Миний Монгол нам (ММН)-ын хөтөлбөр, дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх” тухай өргөдлийг хүлээн авч танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, албан бичгээр хариу хүргүүлсэн.	
40	Улс төрийн намын бүртгэлийн албанд САИНН намаас ирүүлсэн хүсэлтийг 2025.03.28-ны өдрийн 18 дугаар тогтоолоор хуулийн шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзсан хариуг хүргүүлсэн.	
41	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайханаас ЭХХШТХ-ийн шүүгдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой зохицуулалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа эсэхтэй холбоотой албан бичиг ирүүлснийг Шүүхийн академиар судалгаа хийлгүүлэн Нийт шүүгчийн хуралдаанд илтгэж, танилцуулга хийсэн.	Шүүгч Д.Батбаатар
42	Иргэн Б.Одхүүгийн “Нүүдэлчин Монголчуудын Хөгжлийн нам”-ыг бүртгүүлэхээр ирүүлсэн материалтай танилцаж, Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн 2025.03.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж “... зөрчлөө бүрэн арилгаж хуульд нийцүүлэн, дахин хандах боломжтой болохыг дурдаж” 2025.03.10-ны өдрийн 04/752 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.	
43	“Иргэдийн Оролцооны Нэгдэл нам”-ын дарга Ц.Оюунгэрэлээс намын дүрэм /шинэчилсэн найруулга/-ыг бүртгүүлэх тухай өргөдөлтэй танилцаж, Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн 2025.11.06-ны өдрийн хуралдаанаар “... өмнөх тогтоолын зөрчлөө арилгаагүй байх тул өргөдлийг буцаах нь зүйтэй болох”-ыг мэдэгдэж 2025.11.07-ны өдрийн 02/3559 тоот албан бичгээр буцаан хүргүүлсэн.	Шүүгч Б.Цогт
44	Иргэн Б.Одхүүгийн “Нүүдэлчин Монголчуудын Хөгжлийн нам”-ыг бүртгүүлэх тухай дахин ирүүлсэн материалтай танилцаж, Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн 2025.04.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж “...зөрчлөө арилгаагүй байх тул өргөдлийг буцаах нь зүйтэй болох”-ыг мэдэгдэж 2025.04.23-ны өдрийн 02/1324 тоот албан бичгээр буцаан хүргүүлсэн.	
45	Монголын ногоон намын дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг Улсын дээд шүүхийн шийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, хариуг хүргүүлсэн.	
46	“Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-д Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр санал хүргүүлсэн.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
47	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх талаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр санал хүргүүлсэн.	

Мэргэшсэн чиглэлийн дагуу заасан хичээл:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1	Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх сургалт, судалгааны хүрээлэнгээс 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан сургалтад “Гомдол, мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах асуудал” сэдвээр хичээл заасан.	Шүүгч Б.Батцэрэн
2	Хууль зүйн туслалцааны төвөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулсан сургалтад “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт” сэдвээр хичээл заасан.	
3	Шинээр томилогдсон шүүгч нарт “Эрүүгийн хэрэг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа”, “Мэтгэлцэх зарчим” сэдвээр хичээл заасан.	
4	2025.09.10, 11-ний өдрүүдэд Эрүүгийн эрх зүйн чиглэлийн шүүгч-сургагч багш нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийн ойлголт, хууль зүйн шинж, түүнийг тайлбарлан хэрэглэх асуудал сэдвээр хичээл заасан.	Шүүгч Б.Амарбаясгалан
5	2025.10.13-ны өдөр “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийн ойлголт, хууль зүйн шинж, түүнийг тайлбарлан хэрэглэх асуудал” сэдвээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн заавал судлах, мэргэшүүлэх сургалт хичээл заасан.	
6	2025.10.13-ны өдөр “Хэргийн хөдөлгөөний удирдлага” сэдвээр анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн дадлагажуулах сургалтыг удирдан явуулсан.	Шүүгч Ц.Оч
7	Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг Хустайн байгалийн цогцолборт газарт 2025 оны 10 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсан.	

Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1	Шүүхийн академийн Сургалтын хөтөлбөрийн хорооны ээлжит хуралдаанд тухай бүр оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
2	2025.01.15-ны өдөр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч ноён Чарльз Болландыг хүлээн авч уулзсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн
3	2025.01.23-ны өдөр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй шүүгчид Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн,

	хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн үйл ажиллагаатай танилцсан.	Б.Амарбаясгалан
4	2025.01.24-ний өдөр Улсын дээд шүүхээс санаачлан ШЕЗ-ийн гишүүд, нийслэл, дүүргийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан шүүхийн цахимжилт, шүүх эрх мэдлийн ирээдүйн хөгжлийн талаар хэлэлцсэн.	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
5	2025.01.27-ны өдөр “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-ын төслийн талаар Иргэний хэргийн танхимын шүүгчидтэй уулзалт хийсэн.	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
6	2025.01.28-ны өдөр Нийслэл дэх эрүүгийн хэргийн шүүхүүдийн Ерөнхий шүүгч, Тамгын газрын дарга нарыг хүлээн авч Авлигын гэмт хэргийн нээлттэй шүүх хуралдааны шууд дамжуулалтын талаар хэлэлцсэн.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
7	2025.01.31-ний өдөр Ерөнхий боловсролын 161 дүгээр сургуулийн сурагчид Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцах үеэр сурагчдын сонирхсон асуултад хариулж, мэргэжил сонголтод туслах зөвлөгөө өгсөн.	
8	Нийслэлийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 12 дугаар ангийн сурагчид Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцах үеэр тэдний сонирхсон асуултад хариулж, мэргэжил сонгох зөвлөгөө өгсөн.	Шүүгч Б.Цогт
9	2025.01.31-ний өдөр дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн нээлтийн арга хэмжээнд оролцож, үг хэлсэн.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
10	2025.02.06-ны өдөр ХЭҮК-ийн гишүүн Ж.Хунан болон холбогдох мэргэжилтнүүдийг хүлээн авч уулзан, хүүхдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эмзэг хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааны онцлог, хүүхэд хамгаалал болон хүүхдийн эрхийн мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг, чадавхын асуудлыг хөндөн ярилцсан.	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
11	2025.02.13-ны өдөр Улсын дээд шүүхийн Тамгын газраас Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 01-ний өдрийг угтан Ахмадын зөвлөлийн гишүүдээ хүлээн авч хүндэтгэл үзүүлэх ажиллагаанд оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч С.Соёмбо-Эрдэнэ Б.Цогт
12	2025.02.25-ны өдөр Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөлтэй зөрчлийн хэргийн шүүх хуралдааныг цахимаар дамжуулах болон бусад асуудлыг хэлэлцэж хамтарсан уулзалт зохион байгуулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн, С.Соёмбо-Эрдэнэ
13	2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр “Эрүү, зөрчлийн хууль тогтоомжийн нэгдмэл байдал, эрх зүйн шинэтгэл, чиг хандлага, шийдэл” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр

14	2025.03.28-ны өдөр зохион байгуулсан “Эрүү, зөрчлийн хууль тогтоомжийн нэгдмэл байдал, эрх зүйн шинэтгэл, чиг хандлага, шийдэл” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ
15	2025.04.09-ний өдөр НҮБ-ын Хувийн мэдээллээ хамгаалуулах эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Др.Ана Брайан Нугрересыг хүлээн авч уулзсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
16	2025.04.11-ний өдөр “Шүүх засаглалыг бэхжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийн байнгын зөвлөх суурин төлөөлөгч Кристоф Копецкитой уулзсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн
17	2025.04.14-ний өдөр Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэгийн хамт Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх төслийн хүрээнд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /ОУЭЗХБ/-ын төлөөллийг хүлээн авч уулзсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн
18	2025.04.15-ны өдөр Нээлттэй нийгэм форум, “Фиделитас партнерс” ХХН-ийн хамтран зохион байгуулсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдал, хэрэгжүүлэх арга зам” судалгааны тайлангийн хэлэлцүүлэгт оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн, М.Пүрэвсүрэн, Б.Цогт
19	2025.04.18-ны өдөр “Шүүх засаглалыг бэхжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийн удирдагч Андреас Штюветэй уулзсан.	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
20	2025.05.07-ны өдөр “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын агуулгад нийцүүлэх нь” хэлэлцүүлэгт оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
21	“Сэтгэцэд учруулсан хор уршгийг арилгуулах эрх зүйн орчин: асуудал, шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2025.05.13-ны өдөр Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Цагдаагийн хурандаа Ж.Буянбат болон холбогдох бусад албан тушаалтнуудтай хийх уулзалтад оролцсон.	Шүүгч Б.Батцэрэн, М.Пүрэвсүрэн, Б.Цогт, Б.Амарбаясгалан
22	2025.05.23-ны өдөр Иргэний хэргийн танхимтай хамтран “Сэтгэцэд учруулсан хор уршгийг арилгуулах эрх зүйн орчин: асуудал, шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид
23	“Ял оногдуулах жишиг аргачлал”-ын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, 2025.06.02-ны өдөр “Ял оногдуулах жишиг аргачлал”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн хамт “Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт ял оногдуулахад харгалзах хүчин зүйлсийн жишиг тодорхойлох судалгааны тайлан”-тай танилцах уулзалтыг зохион байгуулсан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
24	2025.06.09-ний өдөр Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ле Минь Чий тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
25	2025.06.16, 17-ны өдрүүдэд Улсын дээд шүүх, Шүүхийн академи, Шүүхийн ерөнхий зөвлөл болон АНУ-ын Элчин сайдын яам хамтран АНУ-ын Конгрессын дэргэдэх “Олон улсын манлайллын төв”-өөс (COIL-Congressional Office for	Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид

	International Leadership) шүүхийн салбарт хэрэгжүүлдэг “Нээлттэй дэлхий” хөтөлбөрийн төгсөгчдийн анхдугаар хуралдааныг “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” сэдвийн дор зохион байгуулж, тус бага хуралд оролцсон.	
26	2025.06.27-ны өдөр Шүүхийн академи, Ханнс-Зайделын сантай хамтран зохион байгуулсан “Кибер гэмт хэргийн онцлог, эрх зүйн зохицуулалт” сэдэвт сургалтад хамрагдсан.	
27	2025.06.19-ний өдөр Шүүхийн академиас зохион байгуулсан “Авлига, мөнгө угаах гэмт хэрэг хянан шийдвэрлэх болон хөрөнгө буцаах ажиллагааны онцлог” сэдэвт сургалтад оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
3	2025.11.13, 14-ний өдрүүдэд Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтын онцлог хэрэглээ, нэмэлт, өөрчлөлт сэдвээр сургалт орсон.	
4	Шүүхийн академиас зохион байгуулсан анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчдийг мэргэшүүлэн дадлагажуулах сургалтад Шүүгчийн сайн сайхан байдлын талаар хичээл (2 цаг) заасан.	Шүүгч Г.Банзрагч
5	Шүүхийн академиас зохион байгуулсан анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчдийг мэргэшүүлэн дадлагажуулах сургалтад захиргааны хэргийн шинэ шүүгч нарт “Хууль тайлбарлах хэрэглэх, онол арга зүй” сэдвээр хичээл (4 цаг) заасан.	
6	2025.11.13, 14-ний өдрүүдэд Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд Захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх асуудал сэдвээр сургалт орсон.	
7	2025.11.13, 14-ний өдрүүдэд Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд Нийтийн ашиг сонирхлыг төлөөлж гаргасан нэхэмжлэл, анхаарах асуудал сэдвээр сургалт орсон.	Шүүгч М.Батсуурь
8	2025.09.03-2025.10.04-ний өдрийг хүртэл 5 удаа 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогч нарт зориулан “Захиргааны эрх зүйн актыг хүчингүй болгох нэхэмжлэл”	Шүүгч П.Соёл-Эрдэнэ

	сэдвээр хичээл заасан. /7 хоног бүрийн лхагва гарагт 2 цагаар/	
9	2025.09.15-ны өдөр Шүүхийн академиас зохион байгуулсан Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчдийг мэргэшүүлэн дадлагажуулах заавал судлах сургалтад “Шүүгчийн ажлын зохион байгуулалт” сэдвээр хичээл заасан. /2цаг/	
10	2025.10.24-ний өдөр Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим, Шүүхийн академитай хамтран зохион байгуулсан захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нартай хийсэн уулзалт хэлэлцүүлэгт “Шүүхийн шийдвэр биелүүлэх арга журам” сэдвээр хичээл заасан.	
11	2025.10.24-26-ны өдрүүдэд Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороонд орж ажилласан.	
12	2025.10.31-ний өдөр Өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч нарт “Захиргааны байгууллагын хяналтын цар хүрээ” сэдвээр хичээл заасан.	

Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1	“Шүүхийн шийдвэр бичих аргачлал” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
2	2025.01.24-ний өдөр Улсын дээд шүүхээс зохион байгуулсан “шүүхийн цахимжилт, шүүх эрх мэдлийн ирээдүйн хөгжлийн талаарх” хэлэлцүүлэгт оролцсон.	
3	2025.05.06-ны өдөр Венецийн комиссын дэд ерөнхийлөгч Марта Картабиа тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авах уулзалтад оролцон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд Үндсэн хуулийн цэцийн гишүүний томилгоо, хянан шийдвэрлэх хэргийн харьяалал зэрэг асуудлаар ярилцаж, санал солилцсон.	
4	2025.05.22-ны өдөр Монгол Улсын нийгмийн хамгааллын эрх зүйг боловсронгуй болгох нь ХБНГУ-ын нийгмийн хамгааллын эрх зүй ба сайн туршлага сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.	
5	2025.01.06-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын эрх бүхий албан тушаалтантай Мэргэжлийн нэгдсэн холбооны бүртгэл хөтлөхтэй холбоотой асуудлаар уулзалт хийж, санал солилцсон.	
6	Сургалтын хөтөлбөрийн хорооны 9 удаагийн хуралд оролцсон.	
7	Ёс зүйн зөвлөх хорооны 2 удаагийн хурлыг тус тус зохион байгуулсан.	
8	Ёс зүйн зөвлөх хорооны ажлын талаар Монголын Шүүгчдийн холбоотой хамтран уулзалт хийж, санал солилцсон.	

9	“Шүүхийн цахимжилтын зөөлөн дэд бүтцийг боловсруулж, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг”-ийн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэд ажлын хэсгийн 3 удаагийн хуралд тус тус оролцсон.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
10	2025.04.10-ны өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албаны төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, санал солилцсон.	
11	2025.04.11-ний өдөр “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийн зөвлөх Кристоф Копецкиг хүлээн авч уулзаж, төслийн үйл ажиллагааны талаар санал солилцсон.	
12	“Ерөнхий шүүгчийн сургалт”-ыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, 2 удаагийн хурлыг зохион байгуулж оролцсон.	
13	ШЕЗЗХ-ны ажлын талаар Шүүхийн сахилгын хорооны даргатай уулзалт хийж, цаашдын үйл ажиллагааны талаар санал солилцсон.	
14	Санхүү, эдийн засгийн чиглэлээр захиргааны хэргийн шүүгчдийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах талаар СЭЗДС-ийн захиралтай уулзаж, сургалтын агуулга, хэлбэр, зохион байгуулалтын асуудлаар тохиролцсон.	
15	Канадын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газраас хэрэгжүүлж байгаа “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” (EJAM) төслийн багаас зохион байгуулсан дүгнэлт, уулзалтад оролцож цаашдын үйл ажиллагааны талаарх санал бэлтгэж хэлэлцүүлсэн.	
16	2025.04.10-ны өдөр Монголын шүүгчдийн холбоо, Шүүхийн академитай хамтран шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлийн шүүгч-сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд “Шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэнд” сэдэвт сургалтад оролцсон.	Шүүгч Г.Банзрагч
17	2025.02.07-ны өдөр нийслэлийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад “Эрүү, иргэн, захиргааны хэргийн ялгааг тайлбарлаж, шүүгч гэж хэн болох, өдөр тутамдаа юу хийдэг талаар” мэдээлэл өгсөн.	
18	2025.06.16-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” олон улсын бага хуралд “Шүүхийн үйл ажиллагаа дахь олон нийтийн мэдэх эрхийг хангахад Монгол Улсаас хэрэгжүүлж ирсэн туршлага” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, оролцсон.	Шүүгч М.Батсуурь
19	Америкийн Конгрессын Олон улсын манлайллын албанаас Монгол Улсын шүүхийн салбарт хэрэгжүүлсэн “Нээлттэй дэлхий” хөтөлбөрт хамрагдсан.	
20	2025.12.07-13-ны хооронд Япон Улсын Нагоя Их сургуулийн урилгаар Япон Улсад айлчилж, Монгол Улсын шүүхийн үйл ажиллагаатай холбоотой танилцуулга хийсэн.	

21	2025.06.16, 17-ны өдөр АНУ-ын Конгрессын Олон Улсын манлайллын төв Монгол дахь АНУ-ын элчин сайдын яамнаас зохион байгуулсан “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” сэдэвт олон улсын бага хуралд оролцсон.	Шүүгч П.Соёл-Эрдэнэ, Д.Батбаатар
22	2025.01.31-ний өдөр Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 161 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчдыг Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцуулах, хууль эрх зүйн мэдлэг олгох хөтөлбөрийн хүрээнд хүлээн авч уулзсан.	
23	2025.04.10-ны өдөр Монголын шүүгчдийн холбоо, Шүүхийн академитай хамтран шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлийн шүүгч-сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд “Шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэнд” сэдэвт сургалтад оролцсон.	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
24	2025.04.25-ны өдөр Улсын дээд шүүхийн Тамгын газраас хууль зүйн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг их, дээд сургуулиудтай хамтран “Нээлттэй ажлын байр” өдөрлөгт оролцсон.	
25	2025.05.19-ний өдөр Нийслэлийн Ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдыг хүлээн авч уулзсан.	
26	2025.06.19-ний өдөр Шүүхийн академиас зохион байгуулсан шүүгч-сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд “Насанд хүрэгчдийн заах арга зүй, гадаад орны сайн туршлага” сэдэвт сургалтад оролцсон.	
27	2025.01.24-ний өдөр шүүхийн цахимжилт, шүүх эрх мэдлийн ирээдүйн хөгжлийн талаар хэлэлцүүлэгт оролцсон.	
28	2025.04.11-ний өдөр “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгчийн хамтрагчаар ажиллаж байна. Энэ хүрээнд ажлын төлөвлөгөө бэлдэх, техник уулзалтыг 7 удаа хийсэн.	Шүүгч Ц.Цогт
29	“Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийн удирдагч Андреас Штюве, төслийн байнгын зөвлөх Кристоф Копецки, бүрэлдэхүүн хэсгийн ахлагч, Германаас ирж буй богино хугацааны экспертүүдтэй 10 удаа уулзаж ажиллаж байна.	
30	2025.05.30-ны өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Хелмут Кулицыг хүлээн авч, хамтын ажиллагааны асуудлаар уулзсан.	
31	2025.03.28-ны өдрийн Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын /IDLO/ уулзалтад оролцсон.	
32	2025.06.09-ний өдөр Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ле Минь Чий тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч, хамтын ажиллагааны асуудлаар уулзсан.	

33	2025.02.07-ны өдөр Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн сурагчдыг хүлээн авч, мэдээлэл өгсөн.	
34	2025.06.16, 17-ны өдрүүдэд АНУ-ын Конгрессын дэргэдэх “Олон улсын манлайллын төв”-өөс (COIL–Congressional Office for International Leadership) шүүхийн салбарт хэрэгжүүлдэг “Нээлттэй дэлхий” хөтөлбөрийн төгсөгчдийн “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” олон улсын анхдугаар хуралдааныг зохион байгуулах Ажлын хэсэгт ажиллаж, уг хуралд “Хууль хэрэглээний нэгдмэл байдалд хэрэг судлал ашиглах нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.	
35	Канадын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газраас хэрэгжүүлж байгаа “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” (EJAM) төслийн багаас зохион байгуулсан дүгнэлт, уулзалтад оролцож цаашдын үйл ажиллагааны талаарх уулзалт хэлэлцүүлэгт оролцсон.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, шүүгч Д.Батбаатар, Ц.Цогт
36	Зөрчлийн тухай хууль Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасантай холбоотой Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын дээд шүүхийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, шүүгч Г.Банзрагч
37	2025.09.04-ний өдөр Сонгуулийн ерөнхий хорооны удирдлагуудтай Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой асуудлаар хийсэн уулзалтад оролцсон.	
38	2025.10.06-08-ны өдрүүдэд Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газар болон Улсын дээд шүүх, Шүүхийн академи, Монголын шүүгчдийн холбооны нарын хооронд “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” (EJAM) төслийн хүрээнд уулзалтад үе шаттайгаар оролцож, 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр “Хамтран ажиллах санамж” бичиг байгуулсан.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
39	2025.10.09-ний өдөр Нийт шүүгчийн III чуулганд “Шүүх эрх мэдлийг зохистой хэрэгжүүлэх нь: хариуцлага ба хараат бус байдал” сэдвээр илтгэл тавьсан.	
40	2025.10.24-ний өдөр Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт шүүгчидтэй уулзалт хийж шүүгчийн сургалтын хөтөлбөрийн талаар танилцуулга хийсэн.	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
41	2025.11.07-ны өдөр Улсын дээд шүүхийн Тамгын газар, Сонгуулийн ерөнхий хороотой хамтран зохион байгуулсан бүртгэлтэй намуудын холбогдох хүмүүст Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж баталсан “Шалгах хуудас”-ын талаарх анхаарах асуудлаар мэдээлэл өгсөн.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, шүүгч П.Соёл-Эрдэнэ
42	Монголын шүүгчдийн холбоо, Шүүхийн академитай хамтран шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлийн Judicial Wellbeing шүүгч-сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд “Шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэнд сэтгэл зүйд суурилсан манлайлал ба хамт олны харилцаа” сэдэвт сургалтад хамрагдсан.	Шүүгч Г.Банзрагч
43	Шүүхийн академи, Ханнс-Зайделийн Сангийн хамтран зохион байгуулсан (2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр) Улсын	Шүүгч Г.Банзрагч, Д.Батбаатар

	дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгчдэд зориулсан “Өрсөлдөөний эрх зүй” сэдэвт сургалтад хамрагдсан.	
44	2025 оны 09 дүгээр сард “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийн багийнхантай уулзаж, шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл өгч, харилцан санал солилцсон.	Шүүгч Г.Банзрагч, Ц.Цогт
45	Улсын дээд шүүхээс 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан шүүгчийн судлаач туслах болон судлаач нарт зориулсан сургалт-хэлэлцүүлэгт “Захиргааны хэргийн шийдвэр унших аргачлал, маргааны зүйлийг зөв тодорхойлох” сэдвээр арга зүйн зөвлөмж (2 цаг) өгсөн.	
46	Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр тэргүүтэй холбогдох албаныхан Шүүхийн сахилгын хороо болон Европын Холбоо хамтран хэрэгжүүлж буй Техникийн туслалцаа, мэдээлэл солилцох хөтөлбөр (TAIEX)-ийн хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Европын Холбооны гишүүн орнуудын экспертүүдийг хүлээн авч уулзах уулзалтад оролцож “Хяналтын шатны шүүхэд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар” мэдээлэл өгч, харилцан санал солилцсон.	Шүүгч Г.Банзрагч
47	Нийт шүүгчийн II чуулганаас Улсын дээд шүүхэд ирүүлсэн “Санал уламжлах тухай” 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдлын талаар илтгэсэн.	
48	Улсын дээд шүүх БНСВУ-ын Ардын дээд шүүхтэй Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах арга хэмжээнд 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр оролцсон.	
49	Шүүхийн академи, Улсын дээд шүүх болон Монголын шүүгчдийн холбоотой хамтран “Шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэнд-сэтгэл зүйд суурилсан манлайлал ба хамт олны харилцаа” сэдэвт сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулж, Австрали улсаас Хууль зүйн доктор, сэтгэл судлалын магистр Карли Шревер, сэтгэл судлаач, гэр бүлийн сэтгэл засалч Салли Райан нар хоёр өдрийн хугацаанд удирдан явуулсан.	Шүүгч Д.Батбаатар
50	“Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгчийн хамтрагчаар ажиллаж байна. Энэ хүрээнд ажлын төлөвлөгөө бэлдэх, техник уулзалтууд хийгдэж байна.	
51	Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газар болон Улсын дээд шүүх, Шүүхийн академи, Монголын шүүгчдийн холбоо “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” (EJAM) төслийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 17-нд хамтран ажиллах уулзалтад үе шаттайгаар оролцож, 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр “Хамтран ажиллах санамж” бичиг байгуулалцсан.	Шүүгч Ц.Цогт

52	“Шүүх хуралдаан хойшлогдож буй нийтлэг шалтгаан, шийдвэрлэх зарим боломж” сэдэвт bench&bar уулзалтыг Шүүгчдийн холбооны хүсэлтээр 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан.	
53	2025 оны 10 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Нийт шүүгчийн ээлжит III дугаар чуулганы хуралдаан даргалагчаар ажилласан.	
54	2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэд тэргүүн Аллан Пиреирийг хүлээн авч уулзсан.	
55	2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр ХБНГУ-ын Холбооны Эдийн засаг, эрчим хүчний яамны Европын эдийн засгийн бодлого, дотоодын зах зээлийн газрын Дэд захирал Нина Вундерлихийг хүлээн авч уулзсан.	

Ажлын хэсгийн оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1	Шүүхийн ёс зүйн зөвлөх хорооны ахлагчаар ажилласан.	
2	“Ерөнхий шүүгчдийг мэргэшүүлэх сургалт”-ыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар ажилласан.	
3	“Шүүхийн цахимжилтын зөөлөн дэд бүтцийг боловсруулж, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг”-ийн гишүүнээр ажилласан.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
4	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн үр нөлөөнд мониторинг хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар ажилласан.	
5	Канадын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газраас хэрэгжүүлж байгаа “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” (EJAM) төслийн 2 дахь шатны үйл ажиллагаанд Улсын дээд шүүхээс ажлын хэсэгт ажилласан.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, шүүгч Ц.Цогт
6	Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хэсэгт ажилласан.	
7	Улсын дээд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг сугалаагаар томилох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах боловсруулах ажлын хэсэгт ажилласан.	Шүүгч М.Батсуурь
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажилласан.	Шүүгч П.Соёл-Эрдэнэ

9	Нотариатчидын танхимын Сахилгын зөвлөлийн гишүүнээр ажилласан.	
10	Шүүхийн академиас зохион байгуулсан “Менторшип-2025” хөтөлбөрийн хүрээнд ментор шүүгчээр ажилласан.	
11	Хуульчдын холбооны сургагч багшаар ажилласан.	
12	АНУ-ын Конгрессын дэргэдэх “Олон улсын манлайллын төв”-өөс (COIL–Congressional Office for International Leadership) шүүхийн салбарт хэрэгжүүлдэг “Нээлттэй дэлхий” хөтөлбөрийн төгсөгчдийн “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” олон улсын анхдугаар хуралдааныг зохион байгуулах Ажлын хэсэгт ажилласан.	Шүүгч Ц.Цогт
13	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн үр нөлөөнд мониторинг хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах ажлын хэсгийн ахлагч үүнтэй холбоотой төлөвлөгөө, судалгаа, хурлыг зохион байгуулан ажиллаж байна.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
14	Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна.	
15	Нийт шүүгчийн III чуулганд илтгэл хэлэлцүүлж, зохион байгуулалтад оролцсон.	
16	2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан Нийт шүүгчийн III чуулганд хэлэлцүүлэгчээр оролцсон.	
17	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажилласан.	Шүүгч Г.Банзрагч
18	Нийт шүүгчийн ээлжит III чуулганд Шүүгчийн холбооны тэргүүний хувиар оролцож, холбогдох асуудлыг хэлэлцүүлсэн.	Шүүгч Д.Батбаатар

Контент бүтээх ажлын оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1	“Төрийн албаны тухай хууль хэрэглээтэй холбоотой анхаарах зарим асуудал” хичээл зааж, контент болгосон (Шүүхийн академитай хамтран).	Шүүгч М.Батсуурь
2	“Шүүгчийн онцлог ном” контентод оролцсон.	Шүүгч Х.Батсүрэн
3	2025.04.17-ны өдөр “Бид юу хийдэг вэ” контентод оролцсон.	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
4	2025.04.25-ны өдөр Шүүхийн цаг контентод оролцсон.	
5	2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Захиргааны хэргийн шүүхийн онцлогийн талаар танилцуулсан.	Шүүгч Ц.Цогт

6	“Тэнгэр” телевизийн Мэдээний албаны дарга, ерөнхий продюсертой Танхимын тэргүүн уулзаж, газрын маргаантай холбоотой асуудлаар нэвтрүүлэг бэлтгүүлэхээр эхний зохиолоо өгсөн.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
7	“Хэргийн маргааны төрлөөр контент” Захиргааны хэргийн танхимын шүүгчийн судлаач туслах, Олон нийттэй харилцах мэргэжилтэнтэй хамтран; “Хэрэг хянан шийдвэрлэх процесс” Шүүхийн академитай хамтран ЗХДЗШШ-ийн байранд; “Хэргийн аялал” хэвлэмэл хуудсыг, Албаны дарга, Олон нийттэй харилцах мэргэжилтэнтэй хамтран тус тус зохион байгуулж, хийсэн.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа

Гадаад хурал, зөвлөгөөн, уулзалт, илтгэл, албан томилолт:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1	2025.05.01-ний өдөр НҮБ-ын Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудлаарх Тусгай илтгэгч хоорондын холбогдох хамтын ажиллагааны хүрээнд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд профессор Маргарет Саттервейтийн “Шүүхийн тогтолцоонд хиймэл оюун ухаан ашиглахын хэтийн төлөв ба сорилтууд” сэдэвт илтгэлд хувь нэмрээ оруулах зорилготой онлайн уулзалтад оролцсон.	Шүүгч Ц.Цогт
2	2025.05.12-19-ний өдрүүдэд Канад Улсын Торонто хотод зохион байгуулагдсан “Олон улсын шүүгчдийн холбооны Ази, Хойд Америк, Далайн орнуудын бүсийн хурал”-д оролцсон.	
3	2025.11.23-28-ны өдрүүдэд Парис хотноо болсон OECD байгууллагын хэрэгжүүлдэг Олон улсын татварын эрх зүй: чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Франц Улсын Төрийн зөвлөл, Олон Улсын Энергийн Агентлагтай хамтран зохион байгуулсан Захиргааны хэргийн шүүгч нарт зориулсан “Татварын маргаан шийдвэрлэх чадавхыг дээшлүүлэх” сургалт, хэлэлцүүлэгт Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхтэй холбоотой татварын маргаан шийдвэрлэсэн талаар танилцуулга хийж, илтгэсэн.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа

Бичсэн ном, гарын авлага:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1	Захиргааны хэргийн шүүх 2024 тайлан альбом	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
2	“Эрх зүйт төр ба шүүх эрх мэдэл” сургалтын гарын авлага	Шүүгч Г.Банзрагч
3	Захиргааны эрх зүйн системчлэл, хэрэглээ: Харилцан хамаарал	Шүүгч Ц.Цогт
4	Цахим шүүх ба Шүүх эрх мэдлийн ирээдүй номын редактор хийсэн	
5	Захиргааны хэм хэмжээний акт судалгааны бүтээл хэвлүүлэх	Шүүгч Ц.Цогт, судлаач нар

ГУРАВ. ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЛБА

Улсын дээд шүүх, Шүүхийн Академи, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын дэргэдэх “Олон улсын манлайллын төв” (COIL–Congressional Office for International Leadership)-өөс шүүхийн салбарт хэрэгжүүлдэг “Нээлттэй дэлхий” хөтөлбөрийн Төгсөгчдийн хуралдааныг Улаанбаатар хотод 2025 оны 6 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” сэдвийн дор зохион байгууллаа.



Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ле Минь Чий нар Улаанбаатар хотноо 2025 оны 6 дугаар сарын 09-ний өдөр “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг үзэглэсэн нь хоёр орны хооронд шүүхийн хамтын ажиллагааны асуудлаар байгуулсан анхны санамж бичиг юм. Мөн Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 07 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Сингапур Улсын дээд шүүхэд айлчлал хийж, Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.

Түүнчлэн Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” төслийн нээлтэд оролцож, Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газартай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагааны асуудлаар хэлэлцэж, уулзалт, санамж бичиг байгуулах арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.



Нийт шүүгчийн III чуулганыг Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулж, Ажлын хэсгийн ахлагчаар шүүгч Б.Батцэрэн, гишүүнээр шүүгч Н.Батчимэг, нар ажиллав. Мөн Нийт шүүгчийн III чуулганы мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллээр дамжуулах, олон нийтийн хүртээл болгох чиглэлд Улсын дээд шүүхийн хэвлэл мэдээллийн баг ажиллаж, видео мэдээ, ярилцлага 10, постер мэдээ мэдээлэл 44, холбоос мэдээ 15, нэвтрүүлэг 1, нийт 70 гаруй мэдээллийг бэлтгэн, тухай бүр мэдээллээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн хуралдааныг хоёр жил тутам зохион байгуулахаар заасны дагуу нийт шүүгчийн ээлжит III чуулган 2025 оны 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан.


Чуулганы үеэр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг “Тогтолцооны шинэтгэлээс чанарын дэвшил рүү” сэдэвт илтгэл тавив.



Нийт шүүгчийн III чуулганы “Шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох” хэлэлцүүлгийн панелистаар Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч С.Өмирбек, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг, Судлаач, хуульч Г.Цагаанбаяр нар оролцов.



Ажлын алба нь шүүхийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Шүүхийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх”-д чиглэсэн төсөл боловсруулан ажиллаж байна. Энэ төслийн хүрээнд Улсын дээд шүүхийн цахим хуудас (www.supremecourt.mn)-нд “Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэд”-д зориулсан цэс үүсгэж, шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, түүнчлэн шүүхийн үйл ажиллагааг таниулах зорилгоор “Таны эрх зүйн боловсролд” цуврал 9 видео бичлэгийг дохионы хэл рүү хөрвүүлэн байршуулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэв.



Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Улсын дээд шүүхийн бүтэц, зохион байгуулалт, хуулиар олгосон бүрэн эрх, гадаад харилцаа, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, Шүүхийн академийн үйл ажиллагааны танилцуулга зэргийг товч багтаасан англи хэл дээрх “The Supreme Court of Mongolia” танилцуулгыг хэвлэн гаргалаа.

Түүнчлэн шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах нэгдмэл бодлогын зорилтын хүрээнд 2022 онд анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийн тоймыг хүргэж байсан бол шүүхийн үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах, шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэх зорилгоор хяналтын шатны шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн шийдвэрийн тоймыг эмхэтгэн хэвлүүллээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалтад “шүүхийн практик, тоон мэдээлэлд үндэслэн шүүн таслах ажиллагааны чанар, үр дүн, хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Шүүгчдийн зөвлөгөөнд мэдээлэл хийх” Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг хуульчилсан. Энэхүү чанар, үр нөлөөг хэмжих шаардлага, арга зүй боловсруулах хэрэгцээний талаар Ерөнхий шүүгч 2021 оны илтгэлдээ хөндөж дэвшүүлсэн бөгөөд 2025 онд уг судалгааг хийж гүйцэтгэлээ.

Ажлын албаны үйл ажиллагааны хүрээнд:

Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Шүүгчдийн зөвлөгөөн болон Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, хэрэгжүүлэх бүрэн эрхийг зохицуулсан.

Ерөнхий шүүгчийн Ажлын алба нь Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчдийн зөвлөгөөний зохион байгуулалт, түүний хэвийн, тасралтгүй явуулах бэлтгэл ажлыг ханган ажилладаг бөгөөд 2025 онд Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаан 15 удаа, Шүүгчдийн зөвлөгөөн 8 удаа товлогдож, нийт 109 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.



Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Монгол Улсын шүүхийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын хүрээнд гадаад орнуудын шүүх засаглалын болон олон улсын судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах, шүүн таслах ажиллагааны болон бусад чиглэлээр харилцан туршлага солилцох, байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор олон улсын бүсийн чуулга уулзалт, албан ёсны айлчлал, сургалт, семинар зэргээр шүүгч, шүүхийн захиргааны ажилтны чадавхыг сайжруулах үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлж байна.

Энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан гадаад, дотоодод зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт, хэлэлцүүлэг, төсөл, арга хэмжээ, хоёр болон олон талт гэрээ хэлэлцээр, “Санамж бичиг” байгуулах зэрэг ажиллагаанд хамтран оролцож, дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Тухайлбал:

ХУРАЛ, УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

№	Хурал, уулзалт, хэлэлцүүлгийн агуулга, товч мэдээлэл:
---	---

1	Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид 2025.03.11-21-ний өдрүүдэд Нидерландын Хаант Улс, Бельгийн Хаант Улс, Люксембургийн Их Гүнт Улсын дээд шүүх болон зарим сургалт, судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааны асуудлаар хоёр талын уулзалт;
2	“Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийн удирдагч, Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй, Улсын дээд шүүхийн шүүгчид, холбогдох захиргааны ажилтнууд уг төслийн төслийн удирдагч Андреас Штюве, төслийн байнгын зөвлөх Кристоф Копецки, хэсгийн ахлагч, шүүгч Др.Ард Вайшаупт, Германы олон улсын эрх зүйн хамтын ажиллагааны сангийн ажилтан, төслийн зохицуулагч Катарина Тегедер нарын хамтарсан 2025.04.11, 17-ны өдрүүдийн уулзалт;
3	Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр нар 2025.05.26-ны өдөр АНУ-ын Техас мужийн Рөүзбуд хотын шүүхийн Ерөнхий шүүгч бөгөөд АНУ-ын SPURLOCK шүүхийн сангийн Удирдах зөвлөлийн гишүүн Мэтью Г.Райтыг хүлээн авч, хамтын ажиллагаа, шүүгчийн сургалтын асуудлаар санал солилцсон уулзалт;
4	Ерөнхий шүүгч Д.Ганзориг, шүүгч Ц.Цогт нар 2025.05.30-ны өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Хелмут Кулицыг хүлээн авч, хамтын ажиллагааны асуудлаарх уулзалт;
5	Ерөнхий шүүгч Д.Ганзориг, шүүгч Ц.Цогт, Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг нар 2025.05.30-ны өдөр Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газрын тэргүүн, Элчин сайд Ина Марчюлөните, ХБНГУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хелмут Кулиц, төслийн Герман талын төлөөлөгчид, Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороо, Шүүхийн академийн төлөөлөл зэрэг “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийн Удирдах хорооны гишүүдийг хүлээн авч, төслийн эхний 6 сарын төлөвлөгөөг баталсан уулзалт;
6	Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй Улсын дээд шүүхийн шүүгчид, холбогдох албан тушаалтууд БНСВУ-ын Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ле Минь Чий тэргүүтэй төлөөлөгчдийг 2025.06.09-ний өдөр хамтын ажиллагаа болон “Санамж бичиг”-т гарын үсэг зурах үйл ажиллагаа;
7	Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид 2025 .07.03-05-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Сингапур Улсын дээд шүүхэд айлчлал хийж, Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах ажиллагаа;
8	Ерөнхий шүүгч Д.Ганзориг, шүүгч Д.Батбаатар, Б.Батцэрэн, Тамгын газрын дарга С.Заяадэлгэр нар Бүгд Найрамдах Турк Улсын Хууль зүйн дэд сайд Хуршит Йилдирим тэргүүтэй төлөөлөгчдийг 2025.06.24-ний өдөр хүлээн авч, хамтын ажиллагааны асуудлаар хийсэн уулзалт;
9	Ерөнхий шүүгч Д.Ганзориг 2025.06.30-ны өдөр ХБНГУ-ын Холбооны Эдийн засаг, эрчим хүчний яамны Европын эдийн засгийн бодлого, дотоодын зах зээлийн газрын Дэд захирал Нина Вундерлихийг хүлээн авч уулзаж, хөгжлийн хамтын ажиллагааны асуудлаар хийсэн уулзалт;
10	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг нар Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокурор Нгуен Хуй Тиен тэргүүтэй төлөөлөгчдийг 2025.07.31-ний өдөр хүлээн авч, хамтын ажиллагааны асуудлаар хийсэн уулзалт;

11	Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид 2025.10.06-ны өдөр “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” төслийн нээлтэд оролцож, Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газартай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагааны асуудлаар хийсэн уулзалт;
12	Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, шүүгч М.Пүрэвсүрэн, Тамгын газрын дарга С.Заяадэлгэр нар “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” төслийн төлөөлөгч Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газрын Дэд комиссар Эроулин Хамфрис тэргүүтэй төлөөлөгчдийг 2025.10.08-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар хийсэн уулзалт;
13	Ерөнхий шүүгч “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийн удирдагчийн хувиар 2025.05.30, 2025.06.30, 2025.11.20-ны өдрүүдэд болсон Удирдах хорооны хурлыг даргалж оролцов.
14	Ерөнхий шүүгч “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийн нээлтийг 2025.07.01-ний өдөр хийж, судалгаа, мэдээллээр хангаж, зохион байгуулахад хамтран оролцов.

Дотоод ажлын чиглэлээр:

Тайлангийн хугацаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, иргэдээс Ерөнхий шүүгч болон Улсын дээд шүүхэд ирүүлсэн **912** өргөдөл, гомдол, албан бичгийг хүлээн авч танилцан, зохих журмын дагуу холбогдох танхим, нэгжид нэн даруй шилжүүлж ажиллалаа. Өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийн хугацаа дунджаар **8** хоног байна.

Улсын дээд шүүх болон Шүүхийн академийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан хугацаанд нэгтгэн гаргаж, Үндэсний аудитын газарт хүргүүлэн аудит хийлгэж “Өөрчлөлтгүй” санал, дүгнэлт авсан.

Түүнчлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Аудитын дүгнэлт, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ зэрэг холбогдох бусад баримт, материалыг хуулийн хугацаанд шилэн дансны цахим сайтад байршуулсан.

Шүүхийн талаарх иргэд, оюутан, сурагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 12 дугаар ангийн сурагчдыг, 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Отгонтэнгэр их сургуулийн оюутнуудыг, 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Шихихутуг их сургуулийн оюутнуудыг Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай тус тус танилцуулан, Отгонтэнгэр их сургуулийн оюутнуудыг хүлээн авч “Улсын дээд шүүхийн бүрэн эрх, чиг үүрэг: Шүүхийн шинэтгэл ба хууль хэрэглээний нэгдмэл байдал” сэдвийн хүрээнд мэдээлэл хийв.

Олон нийтийн цахим сүлжээн дэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Ерөнхий шүүгчийн 2 илтгэлийг англи хэл дээр орчуулж, хадмалтайгаар бэлтгэн Улсын дээд шүүхийн Youtube сувагт шинэчлэн нийтэлж, “Хэргийн мөрөөр” нэвтрүүлгийн зохиол боловсруулах, контентод санал өгөх ажлыг гүйцэтгэсэн.

ДӨРӨВ. УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Улсын дээд шүүхийн Тамгын газар хуульд заасан шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллалаа.



Тамгын газар нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 86, 87 дугаар зүйлд заасан чиг үүрэг, “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”, “Монгол Улсын дээд шүүхийн 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-нд үндэслэн 2025 оны төлөвлөгөөг боловсруулж “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх” зорилгыг тусгаж, 5 зорилтын хүрээнд 14 дэд зорилт, 96 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэл 95.5 хувьтай байна.

4.1.ЗАХИРГАА УДИРДЛАГА

Монгол Улсын шүүхийн тухай хууль, бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд захиргааны удирдлагаар хангаж, Улсын дээд шүүхийн Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж ажиллалаа.

Бодлого, төлөвлөлтийн чиглэлээр:

“Монгол Улсын дээд шүүхийн 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зорилгоор Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд холбогдох зорилт, арга хэмжээг тусган ажиллаж “Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” зорилт 98%, “Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах” зорилт 93%, “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах”

зорилт 90%, “Шүүхийн үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх” зорилт 98.5%, “Шүүгч, ажилтны хариуцлага, мэргэжлийн цогц чадамжийг дээшлүүлэх” зорилт 98%-ийн хэрэгжилттэй байна.

“Монгол Улсын дээд шүүхийн 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-ний зорилт, дэд зорилт, арга хэмжээ, гүйцэтгэлийн үнэлгээ (УДШ-ийн ТГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан):

Арга хэмжээний	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Арга хэмжээний Тоо	Гүйцэтгэлийн Хувь
	1		
1.	Зорилт 1. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах	20	98
1.1	Дэд зорилт 1.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох	12	98,8
1.2	Дэд зорилт 1.2.Шүүхийн судалгааны чанарыг дээшлүүлэх	8	96,3
2.	Зорилт 2. Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах	17	93
2.1	Дэд зорилт 2.1.Шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй, ил тод мэдээлэх арга хэлбэрийг сайжруулах	14	95,71
2.2	Дэд зорилт 2.2.Шүүх хуралдааны нээлттэй байдлыг хангах	3	90
3.	Зорилт 3. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах	7	90
3.1	Дэд зорилт 3.1.Шүүхийн бие даасан байдлыг хангах	3	100
3.2	Дэд зорилт 3.2.Шүүгчийн хараат бус байдлыг хангах	4	80
4.	Зорилт 4. Шүүхийн үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх	32	98,5
4.1	Дэд зорилт 4.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг сайжруулах	5	100
4.2	Дэд зорилт 4.2.Шүүхийн үйлчилгээний чанарыг сайжруулах	9	100
4.3	Дэд зорилт 4.3.Шүүхийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх	8	100
4.4	Дэд зорилт 4.4.Шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлэх	8	92,5
4.5	Дэд зорилт 4.5.Ерөнхий шүүгчийн манлайлал	2	100
5.	Зорилт 5. Шүүгч, ажилтны хариуцлага, мэргэжлийн цогц чадамжийг дээшлүүлэх	20	98
5.1	Дэд зорилт 5.1.Шүүгчийн мэдлэг, ур чадвар, манлайллыг нэмэгдүүлэх	2	100
5.2	Дэд зорилт 5.2.Шүүхийн захиргаанд ёс зүй, цогц чадамжтай хүний нөөц бүрдүүлэх, хөгжүүлэх	10	94
5.3	Дэд зорилт 5.3.Шүүхийн хэвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	8	100

Монгол Улсын шүүхийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, холбогдох аргачлалын хүрээнд “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд санал хүргүүлж, “Төрийн бүтээмж, засаглал”-ийн бодлогын чиглэлд холбогдох санал тусгагдсан.



Улсын дээд шүүхийн Тамгын газарт мөрдөгдөж буй 23 дүрэм, журамд дүн шинжилгээ хийж, зарим дүрэм, журмыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулав. Улсын дээд шүүхийн 2024 оны тайлангийн хураангуйг боловсруулж, хэвлэмэл тайлан болгон гаргалаа.

https://www.supremecourt.mn/media/uploads/2025/04/29/tailan_brochure_2025_20429pdf_1745917235076.pdf



Улсын дээд шүүхийн номын сан нь гадаад хэл дээрх 2300 гаруй, дотоодын 4000 гаруй номтойгоор үйл ажиллагаагаа явуулж, номын сангийн сан хөмрөгөө хууль эрх зүйн чиглэлийн ховор ном, товхимлоор өргөжүүлэх, үйл ажиллагааг нь цахимжуулах, цахим эх сурвалж солилцох, хөгжүүлэхэд арга туршлагаа хуваалцах, судалгааны эргэлтэд оруулахад анхааран ажиллаж байна.



Шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр:

Улсын дээд шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хуучнаар нийслэлийн төр захиргааны байрыг шүүхийн байрны стандартад нийцүүлэн бүрэн засварлаж, ашиглалтад оруулав. Ингэснээр хяналтын шатны шүүх хуралдааныг нэг танхимд ээлжлэн явуулдаг байсан нөхцөл байдал өөрчлөгдөж шүүх хуралдааныг нэгэн зэрэг товлон явуулах боломжийг бүрдүүлж, иргэдэд үйлчлэх хэсэг, прокурор, өмгөөлөгчдийн хэсгийг тохижуулж, шүүхийн үйлчилгээний орчин, нөхцөлийг сайжруулав.

Улсын дээд шүүх өөр байранд шилжин байршсантай холбоотой хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн хамгаалалтын бүсийг Тамгын газрын даргын тушаалаар шинэчлэн баталлаа.

Улсын дээд шүүхийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн, гарах үр дагавар, түүнийг арилгах, бууруулах арга хэмжээг тодорхойлж эрсдэлийн үнэлгээ хийх зорилгоор Тамгын газрын даргын 2025 оны А/140 дүгээр тушаалаар шүүхийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх удирдамжийг баталж, удирдамжийн дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Улсын дээд шүүхийн архивт 1974-2005 оны 184 хэрэг 355 хадгаламжийн нэгж, 2013-2024 оны байнга хадгалах 2012 хадгаламжийн нэгж, 1980-2023 оны 70 жил хадгалах 90 хадгаламжийн нэгж, 1994-2023 оны түр хадгалах 2022 хадгаламжийн нэгж байна.

Улсын дээд шүүхийн архив нь анх 1927 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр байгуулагдсан бөгөөд архивын баримтыг он цаг, зохион байгуулалт, асуудал сэдэв, хэргийн төрөл, ач холбогдлоор нь ялгаж, Үндэсний төв архивт нөхөн бүрдүүлэлт хийх ажлыг зохион байгуулав.

Тодруулбал, 1980 онд Үндэсний төв архивын 285 дугаар сан хөмрөгт 01 дүгээр дансаар 1927-1963 оны 1006, 1983 онд сан хөмрөгийн 2 дугаар дансаар 1927-1959 оны 85, 1983 онд мөн хөмрөгт 3 дугаар дансаар 1960-1973 оны 486, 2010 онд сан хөмрөгийн 4 дүгээр дансаар 1971-1995 оны 798, 2025 онд сан хөмрөгийн 5 дугаар дансаар 1996-2012 оны 1039 хадгаламжийн нэгж бүхий дансыг тус тус үйлдэж, Үндэсний төв архивын Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлж хянуулан батлуулж, төрийн архивт 1927-2012 онд хамаарах 3414 хадгаламжийн нэгжийг шилжүүлсэн.

Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн комисс 2025 оны 12 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд Улсын дээд шүүхэд ажиллалаа. Улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн А/111 дүгээр тушаал батлан, улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг 48 арга хэмжээ, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг 30 арга хэмжээтэй тус тус төлөвлөж, 2025 оны улсын үзлэгт амжилттай дүгнэгдлээ.




Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын хүрээнд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журам, стандартад заасан чиг үүргийг Бичиг хэргийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусган батлуулж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”, Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага MNS 5140-2:2021 стандартын дагуу албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөн явуулж байна. Тайлант хугацаанд **943** албан бичгийг үндэсний бичгээр хөтлөв.



Хүлээн авсан албан бичиг, өргөдөл, гомдол, явуулсан бичиг:

Улсын дээд шүүхийн Тамгын газарт **399** өргөдөл, гомдол, **1323** албан бичиг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, эрх бүхий албан тушаалтанд танилцуулсны дагуу холбогдох шүүгч, ажилтнуудад тухай бүр

шилжүүлэн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавьж, **5182** албан бичгийг явуулсан байна.



Цагаатгалын ажлын чиглэлээр:

Улсын Ерөнхий Прокурорын газраас прокурорын дүгнэлт бичиж ирүүлсэн цагаатгалын 8 хэрэг хүлээн авч, үүнээс 5 хэлмэгдэгчид холбогдох 5 хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж, 3 хэргийн прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож шийдсэн байна. Цагаатгалын бүртгэлд 5 хэлмэгдэгчийн мэдээллийг шинээр оруулж, 26 хэлмэгдэгчдийн мэдээллийг нөхөн хөтлөв.

Шинээр олгосон 2 цагаатгалын үнэмлэхийг бүртгэлийн санд бүртгэж, 21 аймаг, 9 дүүргээс ирүүлсэн нөхөх олговор олгосон 49 шүүхийн шийдвэрийн мэдээллийг оруулсан.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст Улсын дээд шүүхээс шийдвэрлэсэн цагаатгалын хэргийн дүн мэдээг хагас болон бүтэн жилээр хүргүүлж хамтран ажиллав.

Санхүү, нийтлэг үйлчилгээний чиглэлээр:

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1.2 дахь заалт “Шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлөөр хангах” гэж заасны дагуу батлагдсан төсвийг цалин, нийгмийн даатгал, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засвар, томилолт, зочны зардал, даатгалын үйлчилгээ, мэдээлэл технологийн үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, ажил олгогчоос олгох тэтгэмж, дэмжлэг, урамшуулал зэрэг зардалд хуулийн хүрээнд зарцуулж, Үндэсний аудитын газраас 2024 оны санхүүгийн тайлагналд “зөрчилгүй” дүгнэлт авсан.

Улсын дээд шүүхийн Тамгын газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 13 төсөл, арга хэмжээний 22 багцад нийт 27 удаагийн тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд амжилттай зохион байгуулав.

Гэрээний чиглэлээр:

Улсын дээд шүүхийн Тамгын газраас иргэн, хуулийн этгээдтэй 2025 онд байгуулсан 106 гэрээг хянан бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.




Олон нийт, хэвлэл мэдээллийн чиглэлээр:

Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр тэргүүтэй төлөөлөгчид сэтгүүл зүйн салбарын төлөөллийг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хүлээн авч, уулзлаа. Уулзалтаар шүүх хуралдааны шууд дамжуулалт, цахимжилт, шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чиглэлээр мэдээлэл өгч, сэтгүүлчдийн зүгээс шүүх хуралдааныгиргэдэд хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг хэрхэн мэдээлэх талаарх асуултад хариулж, санал солилцов.



Улсын дээд шүүхийн www.supremecourt.mn цахим хаяг, Facebook хуудас, “thesupremecourt_of_mongolia” инстаграм, “Supremecourt of Mongolia” youtube зэрэг мэдээллийн сувгийн идэвхтэй хэрэглэгч, дагагч давхардсан тоогоор 262,425 байна.

Тайлант хугацаанд шүүхийн үйл ажиллагааны талаарх олон нийтэд хандсан 92 нэвтрүүлэг, 70 видео мэдээ, 406 постер, текст мэдээг бэлтгэн түгээсэн. Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах чиглэлээр:



Монгол Улсын дээд шүүх Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагатай /IDLO/ хамтран “Шүүхийн ил тод байдал-Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа” уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа. Уулзалтад Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Тамгын газрын дарга С.Заяадэлгэр тэргүүтэй холбогдох мэргэжилтнүүд, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын суурин төлөөлөгч Чарльз Болланд болон тус байгууллагын төлөөллүүд, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн академийн холбогдох албаныхан, шүүхүүдийн Тамгын газрын дарга нар мөн Олон нийттэй харилцах ажилтнууд, төрийн бус байгууллагуудын төлөөлөл, сэтгүүлчид зэрэг 40 орчим хүн оролцлоо.

Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр “Шүүхийн ил тод байдал-Улсын дээд шүүхээс шүүхийн ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ”, Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газрын дарга О.Солонго “Хялбар ажиллагааны шүүхийн /ДЭИХХААШТШ/-ийн өнөөгийн нөхцөл байдал, хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг сайжруулах нь” сэдвийн хүрээнд мэдээлэл өгөв.

Мөн дээрх мэдээлэлтэй холбогдуулан Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн “Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвийн хүрээнд олон улсын туршлага, нэвтрүүлж болох боломжит хувилбарын талаар мэдээлэл хуваалцаж, оролцогчдын асуултад хариуллаа.



Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-аас “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” хоёр дахь шатны төслийн нээлтийн үйл ажиллагаанд Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Тамгын газрын дарга С.Заяадэлгэр нар оролцов. Үйл ажиллагааг нээж Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзоригийн мэндчилгээг Тамгын газрын дарга С.Заяадэлгэр уламжилсан юм.



Монгол Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр тэргүүтэй холбогдох албаныхан Шүүхийн сахилгын хороо Европын холбоотой хамтран хэрэгжүүлж буй Техникийн туслалцаа, мэдээлэл солилцох хөтөлбөр (TAIEX)-ийн хүрээнд Европын холбооны гишүүн орнуудын экспертүүдийг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтад Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Г.Банзрагч, Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга, Ерөнхий шүүгчийн Ажлын албаны зөвлөх М.Хатанзориг Шүүхийн сахилгын хорооны гишүүн Х.Хашбаатар, Шүүхийн сахилгын хорооны Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан референт Б.Одонгоо, Латви улсын Бүс нутгийн Захиргааны хэргийн шүүгч Каспарс Беркис, Польш улсын Ерөнхий болон цэргийн шүүхийн шүүгч бөгөөд Хүний нөөц, зохион байгуулалтын газрын дарга Марта Кожучовска-Варивода, тус улсын Дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч Доминик Чешкевич нар оролцов.

Талууд Монгол, Латви, Польш улсын Шүүхийн сахилгын хорооны тогтолцооны адил болон ялгаатай тал, сахилгын зөрчлийг ямар шат дараатайгаар шийдвэрлэдэг, сахилгатай холбоотой гомдлыг хэрхэн хүлээн авдаг талаар хэлэлцэж, Европын холбооны гишүүн орнуудын экспертүүдээс Шүүгчийн сахилгын хороо, Шүүгчийн ёс зүйн хороо тусдаа байхын сул болон давуу тал, Шүүгчийн үнэлгээний хорооны чиг үүрэг, сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг шүүгчийн тоо зэрэг холбогдох асуултыг асууж, туршлага солилцсон юм.



Хүний нөөц, сургалтын үйл ажиллагааны хүрээнд:

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын хэрэгжилтийн хүрээнд төрийн захиргааны 68, төрийн үйлчилгээний 79 албан хаагч, нийт 147 албан хаагчийн хувийн хэргийг шинэчилж, төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем дэх албан хаагчдын мэдээллийн бүртгэлийн алдаа, зөрчлийг арилгаж, мэдээлэлд зохих өөрчлөлт оруулав.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн захиргааны 124 албан тушаалтанд хамаарах 43 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 124, 125, 126 дугаар тогтоолоор тус тус батлах зөвшөөрөл авч, төрийн үйлчилгээний 126 албан хаагчид хамаарах 58 ажлын байрны тодорхойлолтыг Тамгын газрын даргын 2025 оны А/18, А/19 дүгээр тушаалаар тус тус шинэчлэн батлав.

Авлигатай тэмцэх газарт ХАСХОМ-66, ХАСУМ-36 мэдүүлгийг хүргүүлж хянуулан, хүний нөөцийн чиглэлээр 198 тушаал гаргаж, хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх 58 гэрээг тус тус байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, мөн 45 удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулж, шүүхийн захиргааны ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлсэн.

“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 5 зорилт, 34 арга хэмжээ, “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийн 3 зорилт, 15 арга хэмжээ, “Шинэ ажилтныг дасан зохицуулах, дадлагажуулах хөтөлбөр”-ийн 5 зорилт, 14 арга хэмжээний хэрэгжилт тус бүр 100 хувийн хэрэгжилттэй байна.




4.2. ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА

Улсын дээд шүүхэд ирсэн хэргийг хүлээн авах, бүртгэх, илгээх, шүүн таслах ажиллагааны хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шүүгчийг шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах, шүүх хуралдааны зохион байгуулалт, техник тоног төхөөрөмжийн хэвийн байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд эрүүгийн-983, иргэний-1323, захиргааны-579, сахилгын 2, нийт 2887 хэргийг бүртгэн хүлээн авч, нийслэл болон орон нутагт 2566 хэргийг холбогдох шүүхүүдэд илгээсэн.

Шүүхэд ирсэн болон илгээсэн хэргийг өмнөх онуудтай харьцуулбал:



Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Тус хуулийг хэрэгжиж эхлэхээс өмнө Улсын дээд шүүхэд ирсэн нийт хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцдэг байсан тул 2021-2022 онд ирсэн болон холбогдох шүүхүүдэд илгээсэн хэргийн тоо сүүлийн 3 жилийн дунджаас өндөр байна.

Тайлангийн жилд шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах чиг үүргийн хүрээнд шүүхийн цахим хуудсаар хяналтын шатны шүүх хуралдааны эрүүгийн-143, иргэний-292, захиргааны-171 нийт 606, танхимын нийт шүүгчийн хуралдааны эрүүгийн-933, иргэний-1208, захиргааны-552, нийт 2693 зар, тоймыг олон нийтэд шуурхай мэдээлж ажиллалаа.

Мөн хяналтын шатны 526 шүүх хуралдааны явцыг тасралтгүй хөтөлж, цахимаар шууд дамжуулан, дууны болон дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулсан. Эдгээр хуралдаанд танхимаар 1731, цахимаар 249 оролцогч оролцсон бөгөөд шүүх хуралдааны дэгийг сахиулан шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангаж ажиллав.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаас гарсан 90 мэдэгдэх хуудсыг хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Улсын дээд шүүхэд хиймэл оюун ухаан нэвтрүүлэх ажлын хэсгийг мэдээллээр хангах ажлын хүрээнд танхим тус бүр 28 асуудлын хүрээнд шаардлагатай судалгаа, мэдээллийг бэлтгэн өгч, AI-д суурилсан хяналтын тогтоолын хайлтыг боловсронгуй болгох зорилгоор тогтоолын хайлтын өгөгдлийн төрлийг боловсруулав.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн 481 шүүгчид Улсын дээд шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын стандарт, шүүхийн үзмэрийн танхим, номын сангийн фонд, шүүгчийн албан өрөөний стандартыг танилцуулах ажлыг зохион байгуулав.



Улсын дээд шүүхийн Тамгын газар, МУИС-ийн Хууль зүйн сургуультай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 онд хийх ажлын төлөвлөгөө баталж, дараах арга хэмжээг зохион байгуулав.

- Шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан “Хууль зүйн техник, Судалгааны арга зүй, Хэрэг судлал” багц сургалт-Багш, доктор С.Сүхчулуун, 2025.04.04, 2025.04.11;
- “Нээлттэй ажлын байр” өдөрлөг, 2025.04.25;



- Бид юу хийдэг вэ? Цуврал видео контент;
- “Сэтгэцэд учруулсан хор уршгийг арилгуулах эрх зүйн орчны чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлэгт Нагоя Их сургуулийн профессор, доктор Күрита Масархиро “Сэтгэцэд учруулсан хор уршгийг арилгуулах Япон улсын эрх зүйн тогтолцоо” сэдвээр цахим илтгэл, 2025.05.23;
- Дадлагын оюутнуудыг хүлээн авах ажиллагаа, 2025.09.08;
- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутнуудыг шүүхийн үйл ажиллагаатай танилцуулах хөтөлбөр, 2025.11.20, 2025.12.17;
- Дадлагын оюутнуудад зориулсан төгсөлтийн хөтөлбөр, 2025.12.16.

Улсын дээд шүүхийн Тамгын газар Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуультай хамтран сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх, оюутны хөгжлийг дэмжих зорилготой Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төвийн солилцооны зуны сургалтад хамрагдсан БНСУ-ын Күүмин их сургуулийн оюутнууд Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр танилцаж, оюутнуудад шүүхийн ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаараа мэдээлэл өгөв.



Нийслэлийн Ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчид 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцлаа.



Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд “Шүүхийн цаг” 72 аудио нэвтрүүлэг бэлтгэж, Улсын дээд шүүхийн цахим хуудас болон “Арга билиг” ФМ радиогоор өдрийн 3 удаагийн давталттайгаар нийтэд хүргэж ажиллав.

4.3. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Улсын дээд шүүх нь хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ олон улсын хөгжлийн чиг хандлага, сайн туршлагыг нэвтрүүлэх, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүн байж, хүний эрх, хууль дээдлэх ёсыг сахин хамгаалах байр суурийг илэрхийлэх, харилцан идэвхтэй оролцоог хангах замаар харилцан ашигтай, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж ажиллав.

Улсын дээд шүүхийн гадаад хамтын ажиллагаа нь хоёр талт, олон талт, олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагууд, олон улсын мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах чиглэлд жил бүр өргөжин хөгжиж байна.

Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд уламжлалт харилцаатай Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс, Канад Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хяналтын шатны шүүх, сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүсийн орнууд, тухайлбал, Бүгд Найрамдах Сингапур Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсын хяналтын шүүхтэй харилцаа хамтын ажиллагааг тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүллээ.

Олон талт хамтын ажиллагааны тухайд НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн оюуны өмчийн байгууллага гэх мэт олон улсын байгууллагууд, Олон улсын эрүүгийн шүүх, Арбитрын Байнгын шүүх зэрэг олон улсын шүүхийн байгууллагуудтай харилцааг хөгжүүллээ.

Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудтай харилцах хамтын ажиллагааны хүрээнд Ханнс Зайделийн сан, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Германы олон улсын эрх зүйн хамтын ажиллагааны сан, Нээлттэй Нийгэм Форум, Азийн сан, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.


Олон улсын мэргэжлийн холбоодтой хэрэгжүүлэх хамтын ажиллагааны хүрээнд Олон улсын шүүгчдийн холбоо, Олон улсын шүүхийн сургалтын байгууллагуудын холбоо, Ази, Номхон далайн бүсийн орнуудын эрх зүйн нийгэмлэгтэй тогтмол хамтын ажиллагааг хөгжүүлэн ажиллаж байна.

Улсын дээд шүүхийн гадаад хамтын ажиллагааны нэгэн чухал хэсэг нь эрх зүйн туслалцааг бэхжүүлэх, олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж хүний эрхийг хангах чиглэлд гадаад улсын ижил төрлийн байгууллагатай тасралтгүй хамтран ажиллах чиг үүрэг билээ. Энэ хүрээнд Улсын дээд шүүхээс иргэний болон захиргааны хэргийн хүрээнд шүүхийн даалгавар хүргүүлэх, хилийн чанадаас ирүүлсэн шүүхийн даалгаврыг хүлээн авч харьяалах шүүхээр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулдаг болно.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Бенилюксийн орнуудад албан ёсны айлчлал хийв.

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг Нидерландын Хаант Улс, Бельгийн Хаант Улс, Люксембургийн Их Гүнт Улсад 2025 оны 03 дугаар сард албан ёсны айлчлал хийж, эдгээр орнуудын Дээд шүүхийн Ерөнхийлөгч нартай хоёр талын хэлэлцээ хийж, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Айлчлалын хүрээнд олон улсын эрх зүйн сургалт, судалгааны байгууллагууд, олон улсын шүүхүүдэд зочилж, харилцааны асуудлаар хэлэлцлээ.

Айлчлалын үр дүнд Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академи болон Нидерландын Хаант Улсын Ассерийн Академи хооронд сургалт, судалгаа, академик солилцооны асуудлаарх санамж бичгийг байгуулж, Олон улсын эрүүгийн шүүхэд Улсын дээд шүүхээс дадлагажигч ажиллуулах, Нидерландын Хаант Улсын Гаагийн олон улсын эрх зүйн академийн хөтөлбөрүүдэд Монгол Улсын шүүгчдийг хамруулах, Монгол Улсад зохион байгуулах олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад салбарын шилдэг судлаачдыг оролцуулах зэрэг асуудлаар тохиролцоонд хүрэв.



Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Монгол Улсад айлчлав.

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ле Минь Чий тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 06 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

Айлчлалын үр дүнд шүүхийн хамтын ажиллагааны асуудлаарх Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, талуудын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, шүүх дэх мэдээллийн технологийн хэрэглээний туршлага хуваалцах, эрх зүйн

шинэчлэлийн асуудлаарх мэдээллийг солилцох болон бусад асуудлаар хамтран ажиллахаар тохиролцов.

БНСВУ-ын Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ле Минь Чийгийн айлчлалын мөрөөр тус улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран Монгол Улсад оршин суугаа Вьетнам иргэдэд зориулан Монгол Улсын хууль тогтоомжийг таниулах хамтарсан өдөрлөгийг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулав.



“Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төсөл хэрэгжиж эхлэв.

Улсын дээд шүүх, Европын Холбооны Төлөөлөгчийн газар хамтран “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн дунд хугацааны төслийг хэрэгжүүлж 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулав.



Улсын дээд шүүхийн удирдлага дор хэрэгжүүлэх “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” төсөл нь (I) Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулж, чадавхыг бэхжүүлэх, (II) Шүүхийн тогтолцооны гүйцэтгэл, хариуцлагыг нэмэгдүүлэх, (III) Хүртээмжтэй байдлыг дэмжих, шүүх тогтолцоонд итгэх итгэлийг нэмэгдүүлэх гэсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн академи хамтран хэрэгжүүлж, Герман Улсын туршлагаас суралцаж, Монгол Улсын шүүх эрх мэдлийн салбарын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөмжүүдийг хүлээн авах юм.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Бүгд Найрамдах Сингапур Улсад албан ёсны айлчлал хийв.

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Сингапур Улсын дээд шүүхэд ажиллаж Сингапур Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Сундареш Менонтой хоёр талын уулзалт хийж, Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.



Талуудын байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд шүүгчийн сургалт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, шүүхийн цахимжилтын чиглэлээр харилцан туршлага солилцох, гэр бүл, хүүхдийн шүүхийн тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр тохиролцож, “Шүүхийн цахимжилт ба шүүхийн үйлчилгээн дэх технологийн хэрэглээ” сэдвээр туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулав.

“Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” төсөл хэрэгжиж эхлэв.

Канад Улсын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газартай хамтран хэрэгжүүлэх “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” урт хугацааны төслийн нээлт, хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах ёслол 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагдав.

Төслийн хүрээнд шүүхийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, ялангуяа охид, эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийн гишүүдийн шүүхэд мэдүүлэх эрхийн баталгааг хангахад чиглэсэн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэхээр тогтлоо.

Энэхүү төслийг Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газар хариуцан Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Монголын шүүгчдийн холбоо, Шүүхийн академи тэргүүтэй салбарын байгууллагууд, мөн иргэний нийгмийн болон эмэгтэйчүүдийн байгууллагуудтай хамтран ажиллана.



“Шүүхийн бие даасан, хараат бус байдал ба шүүхийн цахимжилт” сэдэвт олон улсын хурал зохион байгуулав.

Улсын дээд шүүх, Шүүхийн академи, Шүүхийн ерөнхий зөвлөл болон АНУ-ын Элчин сайдын яам хамтран 2025 оны 06 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд АНУ-ын Конгрессын дэргэдэх “Олон улсын манлайллын төв”-өөс (COIL-Congressional Office for International Leadership) шүүхийн салбарт хэрэгжүүлдэг “Нээлттэй дэлхий” хөтөлбөрийн Төгсөгчдийн хуралдааныг “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” сэдвийн дор зохион байгууллаа.



Хурлын үеэр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг “Шүүх эрх мэдлийн ирээдүйн чиг хандлага: Шүүхийн цахимжилт ба хиймэл оюун ухаан” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, “Шүүхэд цахимжилтыг нэвтрүүлснээр хэргийн оролцогчид, өмгөөлөгчид, шүүхийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийг хөнгөвчлөхөөс гадна шүүхэд биеэр ирэх тохиолдлын тоог цөөлөх, зардал багасгах, хугацаа хэмнэх, нээлттэй уян хатан болох зэрэг олон давуу талтай.

Дэлхий дахинд хиймэл оюун ухааныг бүхий л салбарт тэр тусмаа шүүхийн салбарт хэдийнээ нэвтрүүлээд байна. Гэхдээ шаардлага хангасан хиймэл оюун ухаан бүхий технологийг нэвтрүүлэх юм.

Тиймээс шүүхийн салбарт цахимжилт болон хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхдээ харилцан туршлага солилцох, хүний эрхэд суурилсан цахим шүүхийг цогцлоох нь чухал.

Хиймэл оюун ухааныг ашиглах ёс зүйн болон эрх зүйн орчинг бүрдүүлэх, кибер аюулгүй байдлыг хангах шаардлага тулгараад байна” хэмээн онцоллоо.



Тус хуралд АНУ, Армени, Эстони, Индонези, Казахстан, Киргиз, Молдав, Серби, Узбекистан зэрэг 10 гаруй орны 40 шүүгч, эрх зүйч танхим болон цахимаар, Монгол Улсын 80 орчим шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд зэрэг 120 орчим төлөөлөл оролцлоо.

“Шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах нь”, “Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад хэрэг судлал (database, caselaw) ашиглах нь”, “Дижитал эрин үе дэх хиймэл оюун ба шүүх”, “Кибер аюулгүй байдлын асуудлууд”, “Олон нийтийн мэдэх эрх ба шүүхэд итгэх итгэл”, “Дижитал эрин үе дэх шүүхийн сургалт: цахим хэрэгсэл, хиймэл оюуныг хэрэглэх чадварыг хөгжүүлэх нь” зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, харилцан туршлага солилцов.



“Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх байгуулахтай холбогдуулан Улсын дээд шүүх, Шүүхийн академи, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага болон Ханнс-Зайделийн сан хамтран “Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа.



Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг нээлтийн үгэндээ “Гэр бүл, хүүхдийн хэргийг дагнан шийдвэрлэх шүүх байгуулах нь хүүхдийн хууль ёсны эрх ашгийг зохих ёсоор хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох онцлогт нийцсэн нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн ачааллыг зөв хуваарилах, гэр бүлийн хариуцлагыг дээшлүүлэх, эвлэрүүлэн зуучлалын үр нөлөөг ахиулах зэрэг олон талын ач холбогдолтой болохыг харж болно” гэдгийг онцлов.



Хуралд Монгол, Австрали, ХБНГУ, Япон, Нидерланд, БНСУ, БНТУ, АНУ зэрэг найман орны шүүгч, эрдэмтэн, судлаачид “Гэр бүл ба хамтын амьдрал, үрчлэлт, гэрлэлт цуцлалт, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхол, асран хамгаалалт, дундын эд хөрөнгийн харилцаан дахь тулгамдсан асуудал”, “Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа”, “Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба шүүхийн бүтэц, зохион байгуулалт” зэрэг сэдвийн хүрээнд танхим болон цахим хэлбэрээр оролцож, илтгэл хэлэлцүүлэн, харилцан туршлага солилцлоо.

Хуралдааны төгсгөлд Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, хууль зүйн доктор Ч.Хосбаяр “Бидний байгуулах шүүх нь хэрэг маргааны харьяаллыг хуулиар тодорхойлсон, мэргэшсэн шүүгчтэй, шаардлагатай дэд бүтэц, эдийн засгийн нөөцтэй байхаас гадна нотлох ажиллагаа, мэтгэлцээний хууль зүйн стандартыг хангах ёстой” гэв. Мөн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг Монгол Улсад гэр бүл, хүүхдэд ээлтэй мэргэшсэн шүүхийн тогтолцоог бүрдүүлэх, үндэсний бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн чухал алхам болсныг тэмдэглэв.

“БНХАУ-ын Ардын дээд шүүхийн дэргэдэх Шүүгчдийн үндэсний коллежийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр болон холбогдох албаныхан БНХАУ-ын Ардын дээд шүүхийн дэргэдэх Шүүгчдийн үндэсний коллежийн дэд ерөнхийлөгч, профессор Ху Тянье тэргүүтэй төлөөлөгчдийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтад Улсын дээд шүүхийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга, Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга Д.Мөнхбат, референт Б.Сугармаа, БНХАУ-ын Ардын дээд шүүхийн Шүүх хэргийн академийн Судалгааны газрын дарга Шиэ Вэньшөн, Шүүгчдийн үндэсний коллежийн Иргэний болон арилжааны хэргийн сургалт, судалгааны газрын дэд дарга, профессор Ян Сяоли, Сургалтын менежментийн газрын дэд дарга Сяо Жэньчи, Шүүгчдийн цахим сургалтын газрын дэд дарга Лью Фан болон тус коллежийн Өвөрмонгол дахь салбарын захирал Жан Юнгуан нар оролцов.



БНСВУ-ын Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокурор Нгуен Хуй Тиенийг хүлээн авч уулзлаа.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс /БНСВУ/-ын Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокурор Нгуен Хуй Тиен тэргүүтэй төлөөлөгчдийг 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авч уулзлаа.

Уулзалтад Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг, ГХХАА-ны референт З.Гэрэлмаа болон Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, БНСВУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Нгуен Дуан Тань, БНСВУ-ын Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокурорын туслах, прокурор Нгуен Тиен Сон, Хүний нөөцийн хэлтсийн дарга Танг Нгок Туан, Олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга Ву Ти Хай Ен, Ханой хот дахь Давж заалдах шатны шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн орлогч дарга Зыонг Хунг Ен, Хай Фонг хотын Ардын прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч Ву Мань Хунг, Фу Тхо мужийн Ардын прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч Ле Тат Хиеу, БНСВУ-ын дээд прокурорын газрын Ерөнхий прокурорын нарийн бичгийн дарга Фам Хай Ань тэргүүтэй холбогдох албаныхан оролцлоо.



Уулзалтын үеэр талууд хоёр улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж буй ажлуудын талаар мэдээлэл солилцож, нийтийн эрх зүй, мэргэшсэн шүүгч, прокурорын сургалтын үйл ажиллагаа болон олон улсад тулгамдаж буй хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, авлигын эсрэг үйл хэргийг хэрэгжүүлэхэд харилцан туршлага солилцож, хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Улсын дээд шүүх нь шүүхийн дээд байгууллагын хувиар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах бүрэн эрхийн хүрээнд гадаад улсын байгууллагуудын хүсэлтийг хүлээн авч, холбогдох асуудлаар Монгол Улс дахь нөхцөл байдлыг танилцуулах, байр суурь илэрхийлэх, үйл ажиллагаанд шүүх засаглалыг төлөөлөн идэвхтэй оролцож ирлээ.

Тайлант хугацаанд Улсын дээд шүүхийн шүүгч нар НҮБ-ын Хувийн мэдээллээ хамгаалуулах эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Др.Ана Брайан Нугререс, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албаны төлөөлөгчид, Венецийн комиссын дэд ерөнхийлөгч Марта Картабиа тэргүүтэй төлөөлөгчид, Европын Холбооны Техник туслалцаа, мэдээлэл солилцооны төслийн төлөөлөгчдийг хүлээн авч эрх зүйн асуудал, өнөөгийн нөхцөл байдлын талаар санал солилцов.

Улсын дээд шүүхийн шүүгч нар НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Олон улсын шүүгчдийн холбоо, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн олон улсын байгууллагын урилгаар гадаад арга хэмжээнд Улсын дээд шүүхийг төлөөлөн оролцов.



Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны урилгаар Филиппин Улсын Манила хотод зохион байгуулагдсан “Өмнөд болон Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн Шүүхийн шударга байдлын асуудлаарх өндөр хэмжээний хурал”-д оролцсон бөгөөд энэхүү хурлын үр дүнд “Манилагийн мэдэгдэл” баримт бичгийг батлав. Уг баримт бичиг нь дараах агуулгын хүрээнд хэрэгжүүлэх амлалтыг тодорхойлж, олон улсын хамтын нийгэмлэгт хандан уриалга гаргасан

бөгөөд бүс нутгийн улс орнууд энэхүү агуулгын хүрээнд хамтын ажиллагааг цаашид улам бэхжүүлэхээр тохирсон өндөр ач холбогдолтой, хамтын ажиллагааны суурь баримт бичиг болсон.

ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Улсын дээд шүүх нь бусад улсын шүүхийн сургалтын байгууллагууд, хоёр болон олон талын хамтын ажиллагааны хүрээнд цаг үеийн болон манай улсын нөхцөлд нийцүүлсэн тодорхой сэдвээр шүүгч, албан хаагчдыг гадаад сургалтад тогтмол хамруулахыг эрмэлзэн ажиллаж байна.

Улсын дээд шүүхийн шүүгчдийн хувьд салбар эрх зүйн асуудлаар тогтмол сургалтад хамрагдаж, гадаад улсын шүүгч, эрдэмтэн, судлаачтай санал, туршлага солилцох арга хэмжээнд оролцлоо. Тухайлбал, “Хэрэглэгчийн эрх, өрсөлдөөний эрх зүй”, “Олон улсын татварын эрх зүй”, “Халдашгүй байх иргэний эрхийг хангах, шүүхээс заавал зөвшөөрөл авах мөрдөн шалгах нууц ажиллагаа” зэрэг сэдвийн хүрээнд Япон Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Америкийн Нэгдсэн Улсад сургалтад хамрагдав.

Улсын дээд шүүхийн 17 шүүгч, албан хаагч нар 8 удаагийн гадаад сургалтад оролцлоо.

Гадаад улсын шүүх, шүүхийн сургалтын байгууллагуудтай хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад сургагч багш нарыг урьж шүүгч-сургагч багш бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх сургалтуудыг Шүүхийн академи, Монголын шүүгчдийн холбоо, Улсын дээд шүүхийн хэрэгжүүлж буй “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төсөлтэй хамтран зохион байгуулав.

ТӨСЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Улсын дээд шүүх болон Европын Холбоо хамтран “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэллээ.



Монгол Улсад анх удаа хэрэгжиж буй энэхүү хосолмол түншлэлийн төслийн удирдагчаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг ажиллаж байгаа бөгөөд шүүх эрх мэдлийн байгууллагууд гурван бүрэлдэхүүн тус бүрээр нь ахлан ажиллаж байна. Төслийг хэрэгжүүлэхээр сонгогдсон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зөвлөхүүдтэй хамтран шүүх эрх мэдлийн салбарт тулгамдаж буй олон асуудлаар туршлага солилцож, хамтран ажиллах юм. Тухайлбал, “Монгол Улсын шүүхийн олон нийт, хэвлэл мэдээллийн харилцаанд хийсэн үнэлгээний тайлан”, “ХБНГУ-ын шүүгчийн сахилгын хууль тогтоомжийг Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулсан дүгнэлт”, “Шүүхийн академийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” зэрэг тайланг ирүүлсэн бөгөөд шүүгч-сургагч багш нарт зориулсан сургалтын гарын авлагуудыг боловсруулав.

“Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” төслийн Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Улсын дээд шүүхийн хүсэлтийн дагуу эрх зүйн зарим асуудлаар 2025 оны 12 дугаар сард хамтарсан зөвлөгөөн зохион байгуулсан нь цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, өндөр ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Уг зөвлөгөөний үеэр шүүгчид “Ял оноох удирдамж”, “Эрүүгийн хэрэг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх тухай”, “Иргэний хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдчилсан сонсгол зохион байгуулах журам”, “Сэтгэцэд учирсан хохирлыг тооцох аргачлал” сэдвээр Герман улсын туршлагыг сонсож, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газартай хамтран хэрэгжүүлэх “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” таван жилийн хугацаатай төсөл 2025 оны 10 дугаар сард хэрэгжиж эхлэв.



Энэхүү төсөл нь шүүхийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, ялангуяа охид, эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийн гишүүдийн шүүхэд мэдүүлэх эрхийн баталгааг хангахад чиглэсэн үндсэн зорилготой. Төслийн хүрээнд Канад улсын Гэр бүлийн шүүгчдийн төлөөлөлтэй туршлага солилцох цахим уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулав.

ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА

Улсын дээд шүүхийн гадаад хамтын ажиллагааны нэгэн чухал чиг үүрэг нь гадаад улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талын гэрээ болон Монгол Улсын 1999 оны 07 дугаар сарын 21-ний өдөр нэгдэн орсон “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц (1954 он)” олон талын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангаж, иргэний болон эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн туслалцааг харилцан үзүүлж, Монгол улсаас болон хилийн чанадаас солилцож буй шүүхийн даалгаврыг шуурхай хүргүүлэн ажиллаж байна.

Монгол Улсаас хилийн чандад нийт 33 шүүхийн даалгавар илгээснээс Франц 1, БНСУ 9, БНХАУ 12, ОХУ 5, Казакстан 1, Их Британи 1, Их Британийн Виржинийн Арал Улс 1, Австрали 1, Тайвань 1, Италид 1 даалгавар тус тус илгээсэн байна.

Хилийн чанадаас нийт 74 буюу БНХАУ 22, БНСУ 12, ОХУ 23, БНТУ 3, Швейцар 3, Чех 6, АНУ 1, Франц 1, Унгар 1, Иран 1, Беларусь 1 улсуудаас шүүхийн даалгавар тус тус ирснийг харьяалах шүүхэд хүргүүлэв.

Хилийн чанадаас ирсэн шүүхийн даалгавруудыг харьяалах шүүхэд хүргүүлэн гүйцэтгүүлж, нийт 47 даалгаврын хариуг буцаан илгээсэн байна. Хилийн чанадад гүйцэтгүүлэхээр хүргүүлсэн, ажиллагаа нь хийгдэж буй даалгавруудын талаарх нийт 36 лавлагааг илгээв.



4.4.УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ

Улсын дээд шүүх нь Улс төрийн намын бүртгэл хөтлөх журамд заасны дагуу 7 төрлийн бүртгэлийн үйл ажиллагааг явуулах ба 2025 онд намыг шинээр үүсгэн байгуулагдсан, нам өөрчлөн байгуулагдсан, намын дарга, намын дүрмийн нэмэлт өөрчлөлт (шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэхтэй холбоотой өргөдлийг тус тус хүлээн авч, хянан шийдвэрлэх ажиллагааг явууллаа.


Улсын дээд шүүх нь 2025 онд Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой 48 өргөдөл, Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх 15 хүсэлт, лавлагаа, мэдээлэл олгох, бүртгэл хөтлөхтэй холбогдуулан 91 албан бичиг /хүсэлт, тайлбар/, нийт 154 өргөдөл, хүсэлтийг хүлээн авсан.

Үүнээс улс төрийн намын бүртгэлийн 38 өргөдөл, лавлагаа мэдээллийн 56 хүсэлт, мөн бүртгэл хөтлөхтэй холбоотой 33 тайлбар хүсэлтийг холбогдох намын материалд нэгтгэн тус тус шийдвэрлэж, мэргэжлийн нэгдсэн холбооны 15 хүсэлтийг түдгэлзүүлсэн байна. Харин намын бүртгэлийн 10 өргөдөл, лавлагаа, мэдээллийн 2 хүсэлт, нийт 12 өргөдөл, хүсэлтийн үлдэгдэлтэй бөгөөд холбогдох ажиллагаа хийгдэж байна.

Улс төрийн намаас ирүүлсэн өргөдлийг 2024 оны мөн үетэй харьцуулахад 54.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдаж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024-2025 онд намын дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг бүртгүүлэхээр 18 намаас давхардсан тоогоор 45 удаа Улсын дээд шүүхэд хандсан байна.



Улсын дээд шүүхийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар намын бүртгэлтэй холбоотой 40 өргөдлийг хэлэлцэж, 18 өргөдлийг Улсын дээд шүүхийн албан бичгээр буцааж, 22 өргөдлийг тус шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр Ерөнхий шүүгчид танилцуулга хүргүүлсэн.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар 20 өргөдлийг хэлэлцээд 4 өргөдлийг бүртгэж, 16 өргөдлийг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн тогтоолыг гаргасан. Мөн хуралдаанаар 2 өргөдлийг хэлэлцүүлэхээр товлож, 8 өргөдөлд Бүртгэлийн алба холбогдох ажиллагааг явуулж байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтууд нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр хүсэлт гаргасны дагуу Улсын дээд шүүхэд ирүүлсэн дээрх хүсэлтүүдийг түдгэлзүүлсэн, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.


Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах арга хэмжээний хүрээнд Улсын дээд шүүхийн www.supremecourt.mn цахим хуудаст Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг байршуулж, мэдээллийг QR кодоор харах боломжтой болгосон.

The screenshot displays the website of the Mongolian Supreme Court. At the top, there is a navigation bar with the court's logo and name in Mongolian and English. Below this is a menu with various categories like 'НҮҮР ХУУДАС', 'МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ', etc. The main content area is titled 'УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ' (Party Registration). It features a search bar and a table listing registrations for the years 2025 and 2024.

Year	Registration No.	Date	Description
2025	03	2025-01-20	Иргэний хөдөлгөөний намын нэр, үндсэн дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай
	50	2025-09-18	Ардчилсан намын дарга өөрчлөгдөнгийг бүртгүүлэх тухай
2024	01	2024-01-22	Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын нэрийг ШИНЭ нам болгож өөрчилсөн намын дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл (хүсэлт)-ийн тухай

Below the table, there is a QR code and a button labeled 'Мөн үзэх' (View more). To the right, a partial view of a document or form is visible, containing text and a QR code.

Шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлэх зорилтын хүрээнд Улс төрийн намын бүртгэлийн систем хөгжүүлэлтийг хийж, өгөгдлийн санд файлуудыг нэмэх, устгах, засварлах функцийг хөгжүүлж, улс төрийн нам шинээр үүсгэн байгуулах өргөдөл хавсарган ирүүлэх 801 гишүүний бүртгэлийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан шалгаж байна.



Сонгуулийн ерөнхий хорооны хүсэлтийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр тус хорооны болон Улсын дээд шүүх, Тамгын газрын төлөөлөгчдийг оролцуулан “Улс төрийн намуудаас ирүүлж байгаа намын дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэхтэй холбоотой гарч буй асуудал, хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангах” чиглэлээр санал солилцох уулзалтыг зохион байгуулав. Улс төрийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсан, буцаасан шүүхийн шийдвэр болон албан бичгийг судлан, Захиргааны хэргийн танхимын Тэргүүн, шүүгч нартай хамтран “Шалгах хуудас-1, 2, 3”-ын төслийг боловсруулах, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн саналыг авах, тусгах зэрэг чиг үүрэгтэй оролцсон.

Шинээр үүсгэн байгуулагдах нам:

Намыг шинээр бүртгэх үйл ажиллагаа

/шалгах хуудас- 3/

Үйл ажиллагаа	Хууль, журамд нийцсэн эсэхийг шалгах шалгуур	Зөрчил илэрсэн эсэх
УТНТХ-ийн 11 дүгээр зүйл. Улс төрийн нам үүсгэн байгуулах Намыг зохион байгуулах Их Хурал /цаашид “үүсгэн байгуулах хурал” гэх/-аар үүсгэн байгуулна. (11.1)		
Нам үүсгэн байгуулах Их хурлыг зарлан хуралдуулах	- Үүсгэн байгуулагчийн мэдээлэл; - Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг хангасантай холбоотой мэдээлэл, баримт;	
	Хугацаа: - Хурал зохион байгуулах газар, хугацааг нэг сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн эсэхтэй холбоотой баримт. (11.2)	
	Төлөөлөгч: - Намыг үүсгэн байгуулах хуралд оролцсон Төлөөлөгчдийн мэдээлэл: o Тухайн намын гишүүнээр элссэн байх; o Орон нутгаас төлөөлөх төлөөлөгчдийг оролцуулсан байдал /аль аймгийн төлөөлөл болох / (11.3) холбогдох баримтууд;	
	Намын гишүүд: - Намын зорилго, үзэл баримтлал, намын хөтөлбөр, дүрмийг хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр нам үүсгэн байгуулахаар эвлэлдэн нэгдсэн 801 иргэний талаарх мэдээлэл: o Монгол Улсын иргэн; o 18 насанд хүрсэн; o Өөр намын харьяалалгүй; o Өөр хүнээр төлөөлүүлээгүй байх; хуулийн шаардлагыг тус тус хангана. (13.2.3, 14.4.3)	
Хурлын явц	- Хурлын ирцийн мэдээлэл;	

Улс төрийн намуудад “Шалгах хуудас”-ны мэдээллийг хүргэх зорилгоор Сонгуулийн ерөнхий хороогоор дамжуулан олон нийт, намуудад нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулсан.



Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр “Улс төрийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэхэд анхаарах асуудал”-ийн талаар 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн “Шүүхийн цаг” нэвтрүүлэгт, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн NTV телевизийн “Мэдээний цаг” нэвтрүүлэгт тус тус зочноор оролцож, ярилцлага өгөв.

Улсын дээд шүүх, Сонгуулийн ерөнхий хороотой хамтран 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр “Улс төрийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэхэд анхаарах асуудал”-ийн талаарх уулзалтыг зохион байгуулж, 30 намын төлөөлөл оролцож, холбогдох мэдээлэлтэй танилцав.

4.5.МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ЦАХИМЖУУЛАЛТ


Шүүхийн судалгааны чанарыг дээшлүүлэх зорилтын хүрээнд Улсын дээд шүүхийн үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан нэвтрүүлэх боломж, шаардлага, одоогийн нөхцөл байдлын үнэлгээ, технологи ба хүний нөөцийн хэрэгцээ, зорилтот стратегийг тодорхойлох чиглэлээр цогц ажлууд хийгдэж, дараах үр дүнд хүрлээ.

Байгууллагын одоогийн нөхцөл байдлын шинжилгээ:

- байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа системүүдийн архитектур, хүчин чадал, өгөгдлийн уялдаа, дотоод интеграци, шинэчлэл хийх боломжийг техникийн түвшинд дүн шинжилгээгээр тодорхойлсон;

- системүүдийн хооронд өгөгдөл солилцох үйл явц, метадатагийн бүтэц, өгөгдлийн чанар болон давхардлын түвшинг тоон үзүүлэлтээр үнэлсэн;
- үйл ажиллагааны давхардал, автоматжуулалтын боломж, хүний оролцоо өндөр байгаа ажлуудыг тодорхойлж, сайжруулалтын санал боловсруулсан;
- Давхардсан, бүрэн бус, алдаатай өгөгдлийн хэмжээ, шалтгааныг тодорхойлсон.

Зураг:Одоогийн процесс



Хиймэл оюун ухаан нэвтрүүлэх боломжийн судалгаа: Хиймэл оюун ухааныг ашиглаж болох үндсэн салбаруудыг тодорхойлох Улсын дээд шүүхийн үйл ажиллагаанд хамгийн өндөр өгөөж өгөх чиглэл тодорхойлогдсон. Үүнд:


- баримт бичиг ангилах, хураангуйлах, хайлт сайжруулах;
- хэрэг бүртгэл, шийдвэрийн боловсруулалтад дэмжлэг үзүүлэх;
- хууль зүйн судалгаа, мэдээллийн аналитик;
- шүүхийн хуралдааны тэмдэглэл, дуу хоолой таних;
- шүүхийн чатбот (иргэдэд чиглэсэн).

Одоогийн өгөгдлийн архитектурын үнэлгээ:

- Систем, мэдээллийн сангуудын бүтэц, өгөгдлийн урсгал, холболтын аргачлал, ашиглагдаж буй технологиудыг тодорхойлон, хиймэл оюун ухаанд суурилсан систем нэвтрүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн өөрчлөлтийн жагсаалтыг боловсруулсан.

- Шүүхийн өгөгдөл хоорондын хамаарал, солилцооны стандартыг тогтоож, шинэ архитектурын загварын эхний хувилбарыг санал болгосон.

Зураг:Зорилтот архитектур



Өнгөний Тайлбар (Visual Legend - Color Coding)

Өнгө	Төрөл	Тайлбар	Жишээ
Шар	Түгээлт	Хэрэглэгчийн интерфэйс, тайлан гаргал, хандалтын давхарга	BI Тайлангал, Secure API Gateway, AI Search
Цэнхэр	Эх Үүсвэрийн Системууд	Өгөгдөл үүсгэдэг үндсэн систем, өгөгдлийн эх сурвалж	Захиргаа/Эрүүгийн/Иргэний хэргийн систем, ERP систем, Бүтэцгүй файлууд
Улаан	Засаглалын Давхарга	Стратегийн зориулал, Бодлого тогтоох, аюулгүй байдал	Өгөгдлийн Засаглалын Зөвлөл, Хандалтын Нэгдсэн Удирдлага
Улбар шар	Чанарын Хяналт	Өгөгдлийн Чанарын Хяналт, цэвэрлэх	Чанарын Галт Хана (Quality Firewall), баталгаажуулах ажил
Ногоон	Төвлөрсөн Өгөгдлийн Агуулах	Data Lakehouse үндсэн хэсгүүд	ETL/ELT, Bronze/Silver/Gold давхрагууд, AI & NLP Engine
Хөх	Хэрэглэгч	Эцсийн хэрэглэгчид, нэрлэл ашиглагчид	Шүүгч, Ажилтнууд, Иргэд, Supreme Court Portal, Ухаалаг Сансбар
Ягаан	Бичиг Баримт	Бүтэцгүй файл боловсруулалт, текст харгалт	IDP (Intelligent Document Processing), OCR Engine

Баримт материалыг хиймэл оюун ухаанд зориулж хөрвүүлэх ажил:

- Улсын дээд шүүхийн хяналтын тогтоолуудыг JSON формат руу стандартын дагуу хөрвүүлэн, хиймэл оюун ухааны системд ашиглах боломжтой өгөгдлийн сан болгон боловсруулж хүлээлгэн өгсөн.
- Баримт бичгийн метадата, ангиллын бүтцийг тодорхойлж, өгөгдөл боловсруулах стандарт загварын зөвлөмж гаргасан.

Зураг:Хяналтын тогтоолын хөрвүүлэлт

```
1 {
2   "verdict": {
3     "title": "Ж.Э нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай",
4     "type": "upheld",
5     "number": "3",
6     "date": "2020-01-08",
7     "court": {
8       "name": "Монгол Улсын дээд шүүх",
9       "office": "Эрүүгийн хэргийн танхим"
10    },
11    "judge": "Б.Цогт",
12    "panel": [
13      {"name": "Б.Цогт", "role": "Даргалагч"},
14      {"name": "Б.Амарбаясгалан", "role": "Шүүгч"},
15      {"name": "Б.Батцэрэн", "role": "Шүүгч"},
16      {"name": "Ч.Хосбаяр", "role": "Шүүгч"},
17      {"name": "Д.Эрдэнэбалсүрэн", "role": "Шүүгч"}
18    ]
19  },
20  "case": {
21    "number": "100000000",
22    "type": "Эрүүгийн",
23    "received_date": "2019-12-13",
24    "dispute_type": "Хүн амины гэмт хэрэг",
25    "dispute_index": "170/2020/1334/Э",
26    "dispute_number": "1829000000050"
27  },
28  "defendants": {
29    "names": ["Ч.Б", "Ц.А"],
30    "attorneys": [{"name": "И.Олонмөнх", "role": "Өмгөөлөгч"}]
31  },
32  "prosecutor": {
33    "organization": "Улсын Ерөнхий прокуратурын газар",
34    "attorneys": [{"name": "А.Оюунгэрэл", "role": "Хяналтын прокурор"}]
35  },
36  "charges": [
37    {
38      "type": "Эрүүгийн хууль",
39      "description": "Бүлэглэн хүнийг алах",
40      "charge_number": "10.1-2.11",
41      "penalty_imposed": "Ч.Б-д 13 жил, Ц.А-д 12 жил хорих ял"
42    }
43  ],
44  "previous_decisions": [
45  ]
46 }
```

Тогтоолын ерөнхий JSON бүтэц


- verdict_text: тогтоолын бүрэн эх
- decisions: өмнөх шатны шүүхийн мэдээлэл
- descriptive_part: тогтоол дахь тодорхойлох хэсэг
- reasoning_part: тогтоол дахь үндэслэх хэсэг
- operative_part: тогтоол дахь тогтоох хэсэг
- parties: хуралдаанд оролцогчдын мэдээлэл
- laws_cited: иш татсан хуулиуд
- procedural_laws: Процессын хуулиуд.
- substantive_laws: Иргэдийн хуулиар хамгаалагдах эрх үүргийг тодорхойлж, тогтоож өгдөг хуулиуд.
- laws_forming_the_basis_of_the_resolution: Тогтоолын үндэслэл болсон

Шаардлагатай техник, технологи, программ хангамжийн судалгаа:

- Хиймэл оюунд суурилсан систем ажиллуулахад шаардлагатай сервер, GPU, хадгалах төхөөрөмж, сүлжээний хамгаалалтын дэд бүтцийн техникийн үзүүлэлтийн санал боловсруулсан.
- Программ хангамжийн платформ, AI модель сургалтын орчин, нээлттэй эхийн боломжуудын үнэлгээг гаргасан.
- Төсвийн нарийвчилсан тооцоолол, олон хувилбартай (минимал, дундаж, өргөтгөсөн) санхүүгийн загвар гаргасан.

Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор эрүүгийн танхимын 140, захиргааны танхимын 142, иргэний танхимын 282, нийт 564 хяналтын шатны шүүх хуралдааны шууд дамжуулалт(LIVE)-ыг байгууллагын <https://supremecourt.mn> цахим хуудас болон фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулж, иргэд, олон нийтэд хүргэв.


Зураг:Хяналтын шатны шүүх хуралдааны шууд дамжуулалт



Шүүх хуралдааны шууд дамжуулалтын чанарын үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлж, дүрс болон дууны мэдээллийн стандарт, өнгө загварын нэгдсэн байдал, хэрэглэгчдэд ойлгомжтой байлгах чиглэлд анхаарч, шүүх хуралдааны үеэр ашиглагдах титр, завсарлагын үеийн график дизайн, хөдөлгөөнт дүрс бүхий контентуудыг боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглав.


Synology төрлийн сүлжээний хадгалах төхөөрөмж (NAS)-ийг суурилуулж, шүүх хуралдааны аудио, видео бичлэгийг цахим хэлбэрээр найдвартай хадгалах дэд бүтцийг бүрдүүлж, хяналтын шатны шүүх хуралдааны 580 бичлэгийн дуу, дүрсний чанарыг шалган, тус төхөөрөмжид хуулбарлан хадгалж, аюулгүй байдлыг хангасан.

Зураг:Бичлэг хадгалах төхөөрөмж (sinology)





Байгууллагын цахим хуудсанд шүүх хуралдааны зарын хайлт, мэдээ мэдээллийн байрлал өөрчлөлт, “санал хүсэлт авах”, “хуулийн төсөлд санал өгөх” цэсүүдийг хөгжүүлж, хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээг илүү хүртээмжтэй болгосон. Мөн аудио контент оруулах боломжийг бий болгож, тойргийн шүүхийн мэдээллийг админ хэсэгт нэмж, шүүх бүрэлдэхүүний мэдээлэл сонгох боломжийг сайжруулсан.

Зураг: Байгууллагын цахим хуудас



Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх ажил хийгдэж байна.




Шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлэх зорилтын хүрээнд Улсын дээд шүүхийн дотоод харилцааны системд хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн дараах сайжруулалтыг хийв. Үүнд: хэрэглэгчийн интерфэйсийг (UI) ойлгомжтой болгож, мессеж, файл, зураг дамжуулах, стикер илгээх, нэр болон албан тушаалаар хайх боломжтой болж, хэрэглэгч групп чат үүсгэх, админ эрх удирдах функц, бүх төрлийн төхөөрөмжид мэдэгдэл хүлээн авах боломжийг бүрдүүлж, профайл зураг солих үед чанар алдагдуулахгүй хадгалах, Chunk Upload аргаар файл илгээх зэрэг шинэчлэл хийж, хурд сайжирсан.

Байгууллагын үйл ажиллагааг автоматжуулах, хэлтэс, албаны уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн давхардлыг арилгах, ил тод байдал, тайлагналтыг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулах, хянах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Улсын дээд шүүхийн нэгдсэн дотоод систем” (<https://erp.supremecourt.mn>)-ийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.

Тус систем нь хяналт, удирдлагын, хүний нөөцийн, албан бичгийн, өргөдөл гомдлын, байгууллагын дотоод харилцааны, цаг бүртгэлийн, ажил төлөвлөлтийн, үүрэг, даалгаврын, хурлын, хяналт шинжилгээ, үнэлгээний, эрх зүйн актын, цагаатгалын бүртгэлийн, тайлан судалгааны, үйл явдлын /Event module/, файл солилцооны модуль гэсэн дэд системүүдтэй юм.

Зураг: Улсын дээд шүүхийн дотоод нэгдсэн систем



Энэхүү системийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр бүх хэлтэс, нэгж хооронд нэгдсэн нэг платформоор харилцаж, мэдээллийн давхардал болон ажлын ачааллыг бууруулах, цаг хугацаа болон хүн хүчний зардлыг хэмнэх, үйл ажиллагааг илүү оновчтой зохион байгуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдсэн. Тухайлбал:

Хүний нөөцийн удирдлагын дэд систем: ERP систем болон түүнтэй холбогдон ажиллах бусад дэд системүүдийг хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн удирдлагаар хангах ба хүний нөөцтэй холбоотой бүх үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэх, байгууллагын удирдлагыг бодит цаг хугацааны тайлан, мэдээллээр шуурхай хангах, оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих дэд систем юм.

Цаг бүртгэлийн дэд систем: Байгууллагын онцлог, ажилтны ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн гэрээний нөхцөл зэргээс хамаарч, бүтэн цагийн, хагас цагийн, ээлжийн, гэрээт ажлын цагийн хуваариар тохиргоо хийж, бүх төрлийн цаг бүртгэлийн төхөөрөмжтэй холбогдон ажиллах боломжуудтай бөгөөд байгууллагын удирдлага болон албан хаагчдыг ирцийн тайлан, судалгааны бодит цаг хугацааны мэдээллээр хангах болно.

Ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгаврын дэд систем: Ажлын хэсэг хурал, уулзалт зохион байгуулах, үүрэг даалгавар бүртгэх, биелэлтийг тайлагнах үндсэн зориулалттай бөгөөд ажлын хэсгийн хурал гэх мэт бүх төрлийн хурлыг зохион байгуулах, оролцогчдод хурлын товгыг шуурхай хүргэх, үүрэг даалгавар үүсгэх, хариуцах албан хаагчдад хуваарилах, хурал, уулзалтын тэмдэглэл, шийдвэрийг хөтөлж, бүх оролцогчдыг мэдээллээр шуурхай, тогтмол хангаж, ажлын гүйцэтгэлийг бүртгэж, хяналт тавих боломжтой.

Албан бичгийн модуль: Албан бичгийг байгууллагын дотоод ERP системээр дамжуулан цахимаар боловсруулах, хянуулах, баталгаажуулах, мөн тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх боломж бүрдсэн.

Үүний үр дүнд албан бичгийн бүртгэл, боловсруулалт, шийдвэрлэлтийн бүх үе шат цахим хэлбэрт шилжиж, гар ажиллагаа багасаж, шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлсэн.

Тус систем нь Албан бичиг солилцооны дундын системтэй холбогдох боломжтой болсон тул төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хооронд албан бичгийг цахимаар солилцох, хүлээн авах, хариу өгөх, шийдвэрлэх нөхцөл бүрдсэн. Энэ нь байгууллагын

гадаад болон дотоод харилцааг түргэн шуурхай болгож, баримт бичгийн хөдөлгөөний үр ашиг, найдвартай ажиллагааг нэмэгдүүлж байна. Үр дүн:

- Удирдлагыг бодит мэдээллээр шуурхай хангах боломж бүрдсэн;
- Ирц, ажлын цагийг бодит цаг хугацаанд харах боломжтой болсон;
- Хурал, уулзалт, үүрэг даалгаврын зохион байгуулалт хурдан, эмх цэгцтэй болсон;
- Албан бичгийг боловсруулах, хянуулах, батлах, илгээх бүхий л процесс бүрэн цахимжсан;
- Бичиг баримтын эргэлтийн хугацаа богиносж, шийдвэр гаргалт сайжирсан;
- Цаас хэвлэх, бичиг хүргэх, гарын үсэг зөөх зэрэг ажиллагаа багассанаар цаг болон материалын зардал хэмнэх;
- Үүрэг даалгаврын биелэлт, явц, хугацаа бодит цагт хянагдана;
- Хугацаа хэтэрсэн ажлуудыг анхааруулна;
- Ажилчдын ажлын хариуцлага, сахилга бодитоор сайжирна;
- Хяналт-шинжилгээ хариуцсан ажилтан тайлангийн загварыг системд үүсгэж, нэг стандартын дагуу зохион байгуулалттайгаар боловсруулах боломж бүрдсэн;
- Тайланг холбогдох хэлтэс, нэгж, албан хаагчдад цахимаар илгээх боломж бүрдсэн;
- Тайлангийн явц, хугацааны хоцрогдол, гүйцэтгэлийн төлөвийг бодит цаг дээр хянах боломжтой болсон;
- Аль тайланг хэн, хэзээ, ямар хугацаанд илгээсэн талаарх бүртгэл бүрэн лог хэлбэрээр хадгалагддаг болсон;
- Байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй хяналт-шинжилгээ, үнэлгээний бүх тайлан нэг системд төвлөрч, хайлт, нэгтгэл хийх боломжтой болсон;
- Тайлангийн гүйцэтгэлийн мэдээлэлд суурилсан бодит, цаг үеийн мэдээ удирдлагад шууд хүрэх боломж бүрдсэн;
- Өмнөх тайлангууд хадгалагдан үлдэж, харьцуулалт, дүн шинжилгээ хийх боломж бий болсон;
- Том хэмжээтэй файлуудыг аюулгүй, хурдан дотоод сүлжээгээр солилцоно;
- Гадаад cloud ашиглах шаардлага багасна;
- Эрх зүйн актын өмнөх ба шинэ хувилбарыг харьцуулах боломж бүрдсэн.

“Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагч, илтгэгч шүүгчийг сонгох” систем:


“Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагч, илтгэгч шүүгчийг сонгох систем (Сонгох систем)” нь дараах хэрэг, нэхэмжлэл, хүсэлтүүдийн илтгэгч шүүгч, шүүх бүрэлдэхүүн болон шүүх хуралдаан даргалагчийг урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй хуваарилан томилох ажиллагааг бүрдүүлэх зорилготой. Үүнд:

- 1.Хэрэг (Хэргийн хөдөлгөөний нэгдсэн системээс илтгэгч шүүгч сонгогдсон хэргийн бүрэлдэхүүн, даргалагч);
- 2.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт;
- 3.Сахилгын хэрэг;
- 4.Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой өргөдөл;
- 5.Харьяалал тогтоолгох хүсэлт.

Зураг:Шүүх бүрэлдэхүүн, даргалагч сонгох систем

Хэргийн индекс	Шүүх бүрэлдэхүүн	Даргалагч шүүгч	Илтгэгч шүүгч	Хуваарисан	Танхим	Төрөл	Оролцсон	Оролцоогүй	
178923789789	Ч.Хосбаяр Б.Амарбаасалан С.Совмбо-Эрдэнэ	Б.Цогт	Ц.Оч	●	Эрүү	Хяналт	7	0	🔍 🗑️
1789237812389	Б.Амарбаасалан С.Совмбо-Эрдэнэ М.Пүрэвсүрэн	Ч.Хосбаяр	Ц.Оч	●	Эрүү	Хяналт	7	0	🔍 🗑️
178923789123789	Б.Цогт Б.Батцэрэн М.Пүрэвсүрэн	Б.Амарбаасалан	Ц.Оч	●	Эрүү	Хяналт	7	0	🔍 🗑️
789123123	Б.Цогт Б.Батцэрэн С.Совмбо-Эрдэнэ	М.Пүрэвсүрэн	Ц.Оч	●	Эрүү	Хяналт	7	0	🔍 🗑️
1233522345	Б.Батцэрэн Ч.Хосбаяр Б.Амарбаасалан	С.Совмбо-Эрдэнэ	Ц.Оч	●	Эрүү	Хяналт	7	0	🔍 🗑️
123123123	Б.Цогт Ч.Хосбаяр М.Пүрэвсүрэн	Б.Батцэрэн	Ц.Оч	●	Эрүү	Хяналт	7	0	🔍 🗑️

Нийт 6 дата байна < 1 > 10 / хуудас



Сонгох систем нь “Улсын дээд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох журам”-ын шаардлагад үндэслэн дараах боломж, зохицуулалтыг хангасан. Үүнд:

- Илтгэгч шүүгч, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүнийг урьдчилан таамаглах боломжгүй томилох;
- Шүүгчдийг тойрог дотор санамсаргүй сонгох;
- Хүний нөлөөллөөс ангид, хараат бус ажиллагааг хангах;
- Ил тод, баримтжуулсан, бичлэгтэй байдлаар сонголт хийх;
- Шийдвэр гаргалтыг шуурхай, ачааллыг тэнцвэртэй болгох;

- Сонголтын бүх үйлдлийг бүрэн түүх үүсгэж, хяналт хийх боломж бүрдүүлэх.

Эдгээр шаардлагыг программ хангамжийн архитектур, санамсаргүй сонголтын алгоритм, хэрэглэгчийн эрхийн тохиргоо, лог бүртгэлийн модульд тусган хэрэгжүүлсэн.

СОНГОХ СИСТЕМ НЬ:

- Ирүүлсэн хэрэг, хүсэлт, өргөдлийн бүрдлийг шалган бүртгэх;
- Харьяалал тогтоолгох хүсэлтийг огноо, цагийн дарааллаар бүртгэх;
- Хүсэлт, гомдлыг бүртгэсний дараа холбогдох танхимын тэргүүний туслахад цахимаар хүлээлгэн өгөх;
- Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх хэргийг сонгох систем рүү шилжүүлж хуваарилалт эхлүүлэх үйлдэлтэй.

Сонгох систем нь тайлант оны эхэнд баталгаажсан тойргийн мэдээллийг тохируулан ашиглаж дараах төрлийн тойрогт суурилан санамсаргүй сонголт хийнэ:

1. Гомдлын хэргийн тойрог
2. Сахилгын хэргийн тойрог
3. ШИНБ-хүсэлтийн тойрог
4. Улс төрийн намын өргөдлийн тойрог
5. Харьяалал тогтоолгох хүсэлтийн тойрог

Систем нь хэрэглэгчийн гүйцэтгэж буй сонголт болон үйлдлийн дарааллыг дэлгэцийн бичлэг хэлбэрээр хадгалах боломжтой. Энэхүү бичлэг хийх функц нь системд суурилагдсан тул ямар нэгэн нэмэлт программ суулгах шаардлагагүй. Хэрэглэгч бичлэгийг эхлүүлэх, зогсоох, хадгалах зэрэг үйлдлийг системийн дотоод интерфэйсээс шууд удирддаг.

СИСТЕМИЙГ ХЭРЭГЛЭЭНД НЭВТРҮҮЛСНЭЭР БИЙ БОЛСОН ҮР ДҮН:


- ✓ Илтгэгч шүүгч, шүүх бүрэлдэхүүн, хуралдаан даргалагчийг урьдчилан таамаглах боломжгүй санамсаргүй алгоритмаар шударга, тэнцвэртэй томилдог болсон;
- ✓ Сонголтын бүх үйл явц дэлгэцийн бичлэг болон лог бүртгэлээр хадгалагдаж, баталгааждаг болсон нь ил тод байдал, хяналтын боломжийг нэмэгдүүлсэн;
- ✓ Шүүгчдийн ачааллыг тогтоосон тойргуудаас автоматаар санамсаргүй сонгох зохицуулалтаар тэнцвэржүүлж, хүний нөлөөг бүрэн арилгасан;
- ✓ Хэрэг, хүсэлт, өргөдлийг бүртгэх, танхимын туслахад цахимаар хүлээлгэн өгөх зэрэг ажлын урсгал бүрэн цахимжсан;
- ✓ Хэрэглэгчийн бүх үйлдэл системд лог хэлбэрээр хадгалагдаж, эрх бүхий хэрэглэгчид хяналт шалгалт хийх боломжтой болсон;
- ✓ Аюулгүй байдлын хүрээнд нэвтрэлтийн хамгаалалт, өдөр тутмын нөөцлөлт, долоо хоногийн архивлалт бүрэн хэрэгжиж, системийн найдвартай ажиллагаа хангагдсан;

- ✓ “Сонголт”-ын үйл явцыг системийн дотоод функцээр шууд дэлгэцийн бичлэг хэлбэрээр хадгалах боломжтой болж, шаардлагатай үед баталгаажуулалт, нотолгооны эх сурвалж болж ашиглагдах нөхцөл бүрдсэн.

Шүүхийн хэвийн үйл ажиллагаанд техникийн дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд Улсын дээд шүүхийн шинэ байрны Дата төвийн техник хангамж болон сүлжээний зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулах чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлэв.

Дата төвийг шинээр зохион байгуулахад шаардлагатай сервер, тог баригч (UPS), аюулгүй байдлын хяналтын төхөөрөмж (гал, дулаан, чийгшил), галт хана (firewall), серверийн зогсуур (rack), серверийн дэлгэц зэрэг тоног төхөөрөмжийн нарийвчилсан жагсаалтыг гаргаж, төхөөрөмжийг стандартын дагуу байршуулж, суурилуулсан.

Зураг: Дата төв



Дата төвийн үндсэн болон дэд тоног төхөөрөмж (сервер, switch, firewall, access point)-ийн байрлал, портын тохиргоо, төлөв байдлыг шалгаж, серверүүдийг цахилгааны доголдлын үед тасралтгүй ажиллуулах, сэлгэн залгах боломжийг бүрдүүлэх зорилгоор цахилгаан хангамжийн шугамын зохион байгуулалтыг шинэчлэн тохируулж, хэвийн үйл ажиллагааг хангасан.

Сүлжээний зохион байгуулалтын хүрээнд дараах бүтцийн шинэчлэлүүд хийгдсэн:

- Switch-ийн зохион байгуулалт: Байрны давхар бүрд удирдлагатай (Managed) switch суурилуулж, төхөөрөмж бүрийг төв сервер болон интернэт холболттой уялдуулсан.
- Сүлжээний сегментчлэл: Давхар бүрд тусдаа сүлжээний сегмент бүхий дотоод сүлжээг бий болгосон бөгөөд энэ нь ачааллыг тэнцвэржүүлэх, мэдээллийн урсгалыг илүү оновчтой зохицуулах боломжийг бүрдүүлсэн.

4.6.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Улсын дээд шүүхийн Тамгын газар байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд эрх зүйн актыг хадгалсан байдал (2024-2025 он), хяналтын тогтоолыг цахим хуудаст байршуулалт (2024-2025 он), албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн хугацаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын хэрэгжилт, шүүх

хуралдааны бичлэгийг цахим хуудаст байршуулсан байдал, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, шинэ ажилтныг дасан зохицуулах хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөөт бус 2 хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллав.

2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТ

АРГА ХЭМЖЭЭ	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (2024, 2025 оны хагас)												
Хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд эрх зүйн актыг хадгалсан байдал (2024, 2025 оны хагас)				✓								✓
Хяналтын тогтоолыг цахим хуудаст байршуулалт (2024, 2025 оны хагас)					✓							✓
Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа								🔄				
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын хэрэгжилт												
Шүүх хуралдааны бичлэгийг цахим хуудаст байршуулсан байдал												
Мэдээллийн ил тод, нээлттэй байдал												🔄
Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, шинэ ажилтныг дасан зохицуулах хөтөлбөрийн биелэлт												
Төлөвлөгөөт бус-1					✓							
Төлөвлөгөөт бус-2							✓					

Тайлбар:
█ Гүйцэтгэсэн
█ Хийгдэж байгаа
█ Эхлээгүй байгаа (Холбогдох нэгжийн тайлан хүлээгдэж байгаа)
🔄 Зөвлөмжийн биелэлт хүлээгдэж байгаа
✓ Зөвлөмжийг биелүүлсэн

---oOo---